Сургууль цэцэрлэгт хамрагдсан байдлаар авч үзвэл 76.7 хувь нь сургууль, цэцэрлэгт, 5.4 хувь нь мэргэжил болон техникийн эсхүл дээд сургуульд суралцдаг бол 22.1 хувь нь сургууль, цэцэрлэгт огт суралцдаггүй, сургууль завсардсан байна.

*Зураг 1.21. Хараа хяналтгүй хүүхдийн тоо, 2020-2024 он*




*Зураг 1.22. Хараа хяналтгүй хүүхдийн тоо, хүйс, хүүхдийн байдал, асран хамгаалагчаар, 2024 он*




[7] Эцэг эх буюу хууль ёсны бусад төлөөлөгч, эсвэл албан тушаалтны зүгээс тухайн хүүхдийг хүмүүжүүлэх, сургах, тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйн улмаас түүний зан үйлд тавих хяналтгүй болсон хүүхэд болон мөн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хараа хяналтаас гарч тэнүүчлэн амьдарч байгаа хүүхдийг ойлгоно.

*Зураг 1.23. Хараа хяналтгүй хүүхдийн тоо, сургууль цэцэрлэгт хамрагдалт, тоо, хувиар, 2024 он*




*Зураг 1.24. Хараа хяналтгүй хүүхдийн тоо, хараа хяналтгүй/гадуур тэнэсэн/, байсан давтамжаар, хувиар, 2024 он*




*Зураг 1.25. Хараа хяналтгүй хүүхдийн тоо, хараа хяналтгүй байгаа шалтгаанаар, хувиар, 2024 он*



## 1.2.3.3. ХӨДӨЛМӨР ЭРХЭЛЖ БУЙ ХҮҮХЭД[8]



Монгол Улсын хэмжээнд 2024 оны байдлаар **430** хүүхэд хөдөлмөр эрхэлж байгаа гэж бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад **30** хувиар буурсан үзүүлэлттэй байна. Хүйсийн хувьд **87** хувь нь эрэгтэй, **13** хувь нь эмэгтэй бөгөөд үүний 0.9 хувь буюу хөгжийн бэрхшээлтэй 4 хүүхэд байна. Хүүхдийн хувьд 10.3 хувийг нь хагас болон бүтэн өнчин эзэлж байна. Тэдгээрийн 92.3 хувьд ЕБС-д суралцаж, 4.0 хувь нь сургууль завсардсан байна. Асран хамгаалагчдын хувьд 81 хувь нь төрсөн эцэг эх нь, 17.7 хувь нь ах дүү хамаатан садан нь байна

*Зураг 1.26. Хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн тоо, 2020-2024 он*






*Зураг 1.27. Хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн тоо, хүйс, хүүхдийн байдлаар, 2024 он*




[8]Хөдөлмөрийн тухай хуулийн 4.1.6 дах заалтад "Насанд хүрээгүй ажилтан гэж хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд оролцож байгаа 18 насанд хүрээгүй хүүхдийг ойлгоно" гэжээ.
Тогтвортой хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлтээр “Хэт бага наснаасаа ажил хийх, эсвэл бие бялдар, оюун санаа, нийгмийн болон боловсролын хөгжилд нь саад учруулж буй үйл ажиллагаанд оролцож байгаа хүүхдүүдийг хөдөлмөр эрхэлж буй хүүхэд гэж үзэх” гэж үзэх ба 5-17 насны хүүхдийн энэ үзүүлэлтэд тооцно.

*Зураг 1.28. Хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн тоо, сургууль цэцэрлэгт хамрагдалтаар, 2024 он*




*Зураг 1.29. Хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн тоо, асран хамгаалагчаар, тоо, хувиар, 2024 он*




*Зураг 1.30. Хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, мөнгөн олговор, хувиар, 2024 он*




СТАТИСТИК 2024

## 1.2.3.4. ХУРДАН МОРИНЫ УРАЛДААНЧ ХҮҮХЭД[9]



2024 оны байдлаар улсын хэмжээнд нийт **464** уралдаан зохион байгуулагдаж давхардсан тоогоор **16,092** хурдан морины унаач хүүхэд бүртгэгдсэн байна. Ковидын жилийг эс тооцвол жил бүр хурдан морины уралдааны тоо тогтмол өсөж байна.

Хурдан морины уралдааны тоог бүсээр авч үзвэл **15.1** хувь Баруун, **32.1** хувь нь Хангайн, **35.6** хувь нь Төвийн, **13.6** хувь нь Зүүн бүст , **3.6** хувь нь Улаанбаатарт зохион байгуулагджээ.

*Зураг 1.31. Хурдан морины уралдаанч хүүхдийн тоо, уралдааны тоо, 2020-2024 он*



| | 2020 | 2021 | 2022 | 2023 | 2024 |
|---|---|---|---|---|---|
| Уралдааны тоо | 160 | 21 | 59 | 352 | 464 |
| Хурдан морины унаач хүүхдийн тоо | 13 519 | 1 918 | 7 596 | 11 207 | 16 092 |

*Зураг 1.32. Хурдан морины уралдаанч хүүхэд, бүс, аймаг нийслэлээр, 2024 он*




[9]8, түүнээс дээш настай, эрүүл мэндийн байгууллагаас уралдаанд оролцоход эрүүл мэндийн хувьд харшлах шалтгаангүй гэсэн тодорхойлолт авсан, хурдан морины уралдаанд хүүхдийн ослын даатгалд даатгуулсан хүүхдийг ойлгоно. *Үндэсний их баяр наадмын тухай хууль, 10.2, 10.3, 14.7.8 дах заалт*

## 1.2.3.5. ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХЭД[10]



Монгол Улсын хэмжээнд 2024 оны байдлаар нийт **16,055** хүүхэд хүчирхийлэлд өртсөн байна. Хүйсийн хувьд **49.3** хувь эрэгтэй, **50.7** хувь эмэгтэй байна.

Хүчирхийллийн хэлбэрийн хувьд 6,657 буюу 41.5 хувь үл хайхрах, 6041 буюу 37.6 хувь нь сэтгэл санааны, 2967 буюу 18.5 хувь нь бие махбодын, 390 хүүхэд буюу 2.4 хувь бэлгийн хүчирхийлэлд тус тус өртсөн байна.

Хүүхэд хүчирхийллийн 61 хувь нь гэр бүлийн орчинд үйлдэгдэж байгаа бол хүүхдийн хүчирхийлэл үйлдэгч этгээдийн 58.6 хувь нь тэдний төрсөн эцэг эх, 8.6 хувь нь хойд эцэг, эх, 15.5 хувь нь үе тэнгийн хүүхдүүд нь байна.

*Зураг 1.33. Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, хүчирхийллийн хэлбэрээр, 2024 он*




[10]Хүүхдийн эрхийн тухай хуулийн 4.1.3-т “хүүхдийн эсрэг хүчирхийлэл” /цаашид “хүчирхийлэл” гэх/ гэж хүүхдийн хэвийн өсөлт, хөгжил, эрүүл мэнд, аюулгүй байдалд хор хохирол учруулах, бие махбод, сэтгэл санаа, эдийн засаг, бэлгийн дарамт, хүчирхийллийн үйлдэл, эс үйлдэхүй хэлнэ хэмээн тусгажээ.

*Зураг 1.34. Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, хүчирхийлэл үйлдсэн этгээд, хувиар, 2024 он*




*Зураг 1.35. Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, хүчирхийлэл үйлдсэн орчин, хувиар, 2024 он*



*Хүснэгт 1.4. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо, бүс, аймаг нийслэлээр, 2024 он*

| Аймаг /нийслэл | Бүтэн хачин | Хагас өнчин | Эрсдэлт нөхцөлд буй хүүхэд* | Хараа хяналтгүй хүүхэд | Хөдөлмөр эрхэлдэг хүүхэд | Уралдаанч хүүхэд |
|---|---|---|---|---|---|---|
| УЛСЫН ДҮН | 2 576 | 53 077 | 13 219 | 240 | 430 | 16 092 |
| Баруун бүс | 248 | 6 610 | 1 331 | 0 | 188 | 2 283 |
| Баян-Өлгий | 67 | 1 448 | 861 | 0 | 153 | 153 |
| Говь-Алтай | 39 | 1 104 | 29 | 0 | 0 | 636 |
| Завхан | 37 | 1 110 | 192 | 0 | 0 | 548 |
| Увс | 55 | 1 458 | 205 | 0 | 5 | 511 |
| Ховд | 50 | 1 490 | 44 | 0 | 30 | 435 |
| Хангайн бүс | 479 | 10 755 | 4 293 | 46 | 27 | 6 529 |
| Архангай | 42 | 1 453 | 151 | 9 | 10 | 852 |
| Баянхонгор | 62 | 1 324 | 1877 | 27 | 3 | 827 |
| Булган | 35 | 949 | 410 | 0 | 0 | 433 |
| Орхон | 117 | 1 913 | 5 | 0 | 2 | 500 |
| Өвөрхангай | 96 | 1 834 | 250 | 0 | 0 | 1229 |
| Хөвсгөл | 127 | 3 282 | 1600 | 10 | 12 | 1344 |
| Төвийн бүс | 450 | 11 227 | 4 001 | 4 | 104 | 5 11 |
| Говьсүмбэр | 34 | 488 | 19 | 0 | 0 | 439 |
| Дархан-Уул | 76 | 1 861 | 533 | 0 | 0 | 265 |
| Өмнөговь | 65 | 1 919 | 544 | 0 | 17 | 924 |
| Дорноговь | 31 | 1 336 | 796 | 4 | 2 | 1 328 |
| Дундговь | 47 | 1 878 | 274 | 0 | 0 | 115 |
| Сэлэнгэ | 104 | 2 020 | 258 | 0 | 0 | 352 |
| Төв | 93 | 1 725 | 1577 | 0 | 85 | 1 588 |
| Зүүн бүс | 209 | 4 558 | 1 515 | 21 | 36 | 2 563 |
| Дорнод | 96 | 1 401 | 859 | 21 | 33 | 913 |
| Сүхбаатар | 31 | 1 272 | 462 | 0 | 3 | 1 056 |
| Хэнтий | 82 | 1 885 | 194 | 0 | 0 | 594 |
| Улаанбаатар | 1 190 | 19 927 | 1 801 | 169 | 75 | 1 184 |

## 1.2.4. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХАРИУ ҮЙЛЧИЛГЭЭ

### 1.2.4.1. ХАМТАРСАН БАГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Улсын хэмжээнд 2024 оны байдлаар **764** хамтарсан багийн 6083 гишүүн нийт **9,743** хүүхдэд үйлчилгээ үзүүлж, хамтарсан багийн үйл ажиллагаанд нийт 77,644,497 төгрөг зарцуулсан байна. Үйлчилгээ авсан хүүхдийн 56.1 хувь нь эмэгтэй, **0.8 хувь нь** буюу 75 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна. Үйлчилгээ үзүүлсэн төрлөөр авч үзвэл зөвлөгөө мэдээлэл өгсөн 42.9 хувь, Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвд байрлуулсан 31.9 хувь, төрөл садны хамгаалалтад өгсөн 25.2 хувийг эзэлж байна.

*Зураг 1.36. Хамтарсан баг, үйлчилгээний төрлөөр, хувиар, 2024 он*

**ХАМТАРСАН БАГ**



Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5.1.4 дэх заалтад " Хамтарсан баг гэж хохирогч, түүний гэр бүлийн гишүүнд энэ хуулийн 37, 38.1.1, 40, 41, 42 дугаар зүйлд заасан үйлчилгээг хамтран үзүүлэх сум, хорооны Засаг даргаар ахлуулсан зохион байгуулалтын хэлбэрийг" хэлнэ гэж тусгасан байна.




*Хүснэгт 1.5. Хамтарсан багийн үйлчилгээ, 2020-2024 он*

| Үзүүлэлт | 2020 | 2021 | 2022 | 2023 | 2024 |
|---|---|---|---|---|---|
| Хамтарсан багийн тоо | 684 | 731 | 720 | 806 | 764 |
| Хамтарсан багийн гишүүдийн тоо | 5 649 | 6 063 | 6 113 | 6 508 | 6083 |
| Хамрагдсан хүүхдийн тоо | 5 541 | 11 897 | 12 200 | 6 233 | 9 743 |
| Нийт зардал /мян.төгрөг/ | 384 033.9 | 806 490.7 | 980 524.5 | 363 458.7 | 77 644.5 |

*Зураг 1.37. Хамтарсан багийн үйлчилгээ, үйлчилгээнд хамрагдсан шалтгаанаар, хувиар, 2024 он*




## 1.2.4.2. ТҮР ХАМГААЛАХ БАЙР, НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ[11]



Улсын хэмжээнд 2024 оны байдлаар **22** түр хамгаалах байр, **17** нэг цэгийн үйлчилгээний төвөөр **2,289** хүүхэд үйлчлүүлсэн байна. Үүний 56.9 хувь нь эмэгтэй, 1.9 хувь буюу 43 нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна. Тэдний асран хамгаалагчийн 90.2 хувь төрсөн эцэг, эх нь байна.

Хүүхдийн түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн давтамжийг авч үзэхэд 79.5 хувь нь анхны удаа, 14.7 хувь нь хоёр дахь удаа, 3.8 хувь нь 3 дахь удаа, 2.0 хувь нь 4-өөс дээш удаа үйлчлүүлсэн байна

*Хүснэгт 1.6. Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн тоо, үйлчилгээ авсан хүүхдийн тоо, 2020-2024 он*

| Үзүүлэлт | 2020 | 2021 | 2022 | 2023 | 2024 |
|---|---|---|---|---|---|
| Түр хамгаалах байрны тоо | 16 | 16 | 17 | 22 | 22 |
| Нэг цэгийн үйлчилгээний төв | 14 | 19 | 17 | 17 | 17 |
| Хамрагдсан хүүхдийн тоо | 2147 | 2916 | 3226 | 3308 | 2289 |

[11]Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30.1 дэх заалтад "...Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах зорилгоор хүүхдийг нэг цэгийн үйлчилгээний төв, эсхүл түр хамгаалах байранд хүргэж хүүхдийг тусгай хамгаалалтаар хангах" гэж тусгасан.

*Зураг 1.38. Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн хүүхдийн тоо, хүйс, хүүхдийн байдлаар, тоо, хувиар 2024 он*




*Зураг 1.39. Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн хүүхдийн тоо, асран хамгаалагчаар, хувиар 2024 он*




*Зураг 1.40. Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн хүүхдийн тоо, үйлчлүүлсэн давтамжаар, тоо хувиар, 2024 он*



*Зураг 1.41. Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо, үйлчилгээ авсан шалтгаанаар, хувиар, 2024 он*




*Зураг 1.42. Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн тоо, бүс, аймаг нийслэлээр, 2024 он*



## 1.2.4.3. ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХУУЛЬ ЗҮЙН ХОРОО

Монгол Улсын хэмжээнд 2024 оны байдлаар 38 хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны 466 гишүүн **1,537** хүүхдэд нийгэм эрх зүйн туслалцаа үйлчилгээ үзүүлжээ. Тэдгээрийн **23.2 хувь** нь хууль зөрчсөн, **12.0 хувь** нь гэмт хэргийн гэрч, **48.8 хувь** нь гэмт хэргийн хохирогч, **8.1 хувь** нь гэмт хэргийн сэжигтэн, **7.0 хувь** нь гэмт буруутай ч ял хойшлогдсон, **0.8 хувь** нь сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдүүд байна

*Зураг 1.43. Хүүхдийн эрхийн хууль эрхзүйн хороо, үйлчилгээний төрлөөр, хувиар, 2024 он*

**ХҮҮХДИЙН ХУУЛЬ ЭРХЗҮЙН ХОРОО**



40.1.Аймаг, дүүргийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий хүүхдийн эрхийн хууль зүйн хороо /цаашид "хууль зүйн хороо" гэх/-г тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай зөвшилцөн байгуулна.




*Хүснэгт 1.7. Хүүхдийн эрхийн хууль эрхзүйн хорооны үйлчилгээ, үндсэн үзүүлэлт, 2020-2024 он*

| Үзүүлэлт | 2020 | 2021 | 2022 | 2023 | 2024 |
|---|---|---|---|---|---|
| Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны тоо | 32 | 32 | 32 | 38 | 38 |
| Хууль зүйн хорооны гишүүний тоо | 362 | 413 | 413 | 466 | 522 |
| Үйлчилгээ авсан хүүхдийн тоо | 852 | 603 | 1 682 | 1 840 | 1 537 |

*Зураг 1.44. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороогоор үйлчлүүлсэн хүүхэд, төрлөөр, тоо хувиар 2024 он*



**Хүүхдийн хууль эрхзүйн хорооны үйлчилгээ, үйлчилгээ үзүүлсэн хүүхэд**

| Төрөл | Тоо | Хувь |
|---|---|---|
| Зөрчил гаргасан хүүхэд | 357 | 23.2% |
| Гэрч хүүхэд | 185 | 12.0% |
| Хохирогч хүүхэд | 750 | 48.8% |
| Сэжигтэн хүүхэд | 125 | 8.1% |
| Ял хойшлогдсон хүүхэд | 108 | 7.0% |
| Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхэд | 12 | 0.8% |

## 1.2.4.4. ХҮҮХДИЙН ЭРХИЙН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ШИЙДВЭРЛЭСЭН ЗӨРЧИЛ

Монгол Улсын хэмжээнд 2024 оны байдлаар Хүүхдийн эрхийн ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч-**8**, улсын байцаагч-**36** албан хаагчид Зөрчлийн тухай хуулийн **22** зүйлийн хүрээнд **183 хүүхдийн** зөрчлийг шалгаж ажилласан бөгөөд үүнээс шийдвэрлэсэн **155** буюу **84.5 хувь**, **28** буюу **15.3 хувьд** нь хяналт шалгалт үргэлжилж, нийт 103 зөрчилд торгуулийн арга хэмжээ авч 41.450.0 мянган төгрөгийн мөнгөн торгууль ноогдуулсан байна.

*Зураг 1.45. Хүүхдийн эрхийн улсын байцаагч, хууль эрх зүйн тодорхойлолт, 2024 он*

**ХҮҮХДИЙН ЭРХИЙН УЛСЫН БАЙЦААГЧ**



Хүүхдийн эрхийн тухай хуулийн 20 дугаар зүйл



20.2.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хүүхдийн эрхийн улсын ерөнхий байцаагчийн эрх эдлэх бөгөөд хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр мэргэшиж, сургалтад хамрагдсан ажилтанд улсын байцаагчийн эрх олгоно.



20.3.Хүүхдийн эрхийн улсын байцаагч нь хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр мэргэшүүлсэн сургалтад хамрагдсан, тухайн чиглэлээр нэгээс доошгүй жил ажилласан, хүмүүнлэгийн болон нийгмийн ухаан, хууль зүйн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн байна.



20.4.Хүүхдийн эрхийн улсын байцаагч нь гэр бүл, нийгмийн орчинд хүүхдийн эрх хангагдаж байгаа эсэхэд хяналт тавих, хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах, хүүхдийн эрхийн зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, шалган шийдвэрлэх замаар хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангуулна.

*Хүснэгт 1.8. Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн шийдвэрлэсэн зөрчлийн үзүүлэлт, 2020-2024 он*

| Үзүүлэлт | 2020 | 2021 | 2022 | 2023 | 2024 |
|---|---|---|---|---|---|
| Зөрчил, өргөдөл гомдлын тоо | 125 | 118 | 122 | 187 | 127 |
| Шийдвэрлэсэн | 86 | 89 | 110 | 169 | 64 |
| Шалгаж байгаа | 39 | 27 | 12 | 18 | 727 |
| Торгуулийн хэмжээ /мян.төг/ | 7 760.6 | 10 201.3 | 28 400.0 | 25 400.0 | 41 450.0 |

*Зураг 1.46. Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн шийдвэрлэсэн зөрчлийн мэдээ, 2024 он*

Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн

| Заалт | Зөрчил | Тоо |
|---|---|---|
| 6.20.1.1 | Хүүхдийг хувцас, хоол хүнс, орон байраар зориуд гачигдуулах | 1 |
| 6.20.1.4 | Хүүхдийг асран хамгаалах, тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй | 46 |
| 6.20.2.1 | Хүүхдийг утаат тамхи татахыг санал болгох, дэмжлэг үзүүлэх; | 1 |
| 6.20.2.2 | Хууль ёсны өмчлөх, өв залгамжлах, хөлс, урамшуулал авах эрхийг хязгаарлах; | 3 |
| 6.20.2.3 | Хүүхдийн сурч боловсрох, хөгжих, оролцох, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хязгаарлах | 18 |
| 6.20.3.2 | Хүүхдийн асран хамгаалагчийн зөвшөөрөлгүйгээр гэрэл зураг, дуу бичлэгийг мэдээлэл, сурталчилгаанд ашигласан | 2 |
| 6.20.3.3 | Хүүхдийн нэрийг хууль бусаар ашиглах, амь нас эрүүл мэнд, нэр хүндэд аюул учруулах | 33 |
| 6.20.4 | Хүүхдийн хүсэл зоригын эсрэг шашны үйл ажиллагаанд татан оролцуулах | 1 |
| 6.20.5 | Хүүхдийн байгууллага хүүхдэд аюулгүй ээлтэй орчин бүрдүүлэх үүргээ биелүүлэхгүй байх | 19 |
| 6.20.7 | Хүүхдийн бие махбодид халдах, архидан согтуурах, мансуурах | 41 |
| 6.20.8 | Хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах орчин нөхцөлийг шалгах үүргээ биелүүлээгүй | 11 |
| 15.2.1.1 | Хүүхдийн байгууллага албан хаагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй | 3 |
| 15.2.1.2 | Хууль ёсны дагуу шаардсан мэдээллийг гаргаж өгөхгүй байх, худал мэдээлэл өгөх | 2 |
| 15.2.1.3 | Хүүхдийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаанд саад учруулах хөндлөнгөөс нөлөөлөх | 2 |

## 1.2.4.5. ХҮҮХДИЙН 108 УТАСНЫ ДУУДЛАГА ҮЙЛЧИЛГЭЭ

Хүүхдийн тусламжийн 108 утас нь 7 хоногийн 24 цагийн турш Монгол Улсын өнцөг булан бүрээс 0-18 насны хүүхдийн хамгаалал, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийн эрхийн зөрчлийн тухай мэдээллийг үнэ төлбөргүй хүлээн авч, холбон зуучлах, шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх зэрэг хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлж байна.

*Зураг 1.47. Хүүхдийн 108 утасны дуудлага үйлчилгээний үзүүлэлт, 2024 он*




*Хүснэгт 1.9. Хүүхдийн 108 утасны дуудлага үйлчилгээний үзүүлэлт, 2020-2024 он*

| Үзүүлэлт | 2020 | 2021 | 2022 | 2023 | 2024 |
|---|---|---|---|---|---|
| Нийт дуудлагын тоо | 118 662 | 99 579 | 111 776 | 111 223 | 101 321 |
| А.Бүртгэсэн тохиолдлын тоо /Кейсийн тоо/ | | | | | |
| Кейсийн тоо | 7 544 | 8 102 | 9 294 | 10 436 | 10 821 |
| Хаагдсан кейс | 7 157 | 6 889 | 7 526 | 8 781 | 9 457 |
| Б.Дуудлагын ангилал | | | | | |
| Хүүхдийн эрх хамгаалал | 21 656 | 18 746 | 16 300 | 14 559 | 13 167 |
| Зөвлөгөө | 9 228 | 7 817 | 8 692 | 6 590 | 5 509 |
| Мэдээлэл | 38 604 | 45 305 | 39 693 | 43 042 | 46 006 |
| Шуурхай тусламж,үйлчилгээ | 1 045 | 998 | 1 274 | 1 188 | 1 222 |
| Санал, гомдол | 168 | 40 | 126 | 113 | 103 |

*Хүснэгт 1.10. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, үйлчилгээний төрлөөр, бүс, аймаг нийслэлээр, 2024 он*

| Аймаг/ нийслэл | Хүүхдийн хууль зүйн хорооны үйлчилгээ | Хамтарсан багийн үйлчилгээ | Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээ | Хүүхэд харах үйлчилгээ | Төвлөрсөн асрамж, халамж үйлчилгээ | Уралдаанч хүүхэд |
|---|---|---|---|---|---|---|
| **УЛСЫН ДҮН** | **1 537** | **9 743** | **2 289** | **14 168** | **895** | **16 092** |
| **Баруун бүс** | **215** | **737** | **221** | **1026** | **0** | **2 283** |
| Баян-Өлгий | 29 | 186 | 68 | 317 | 0 | 153 |
| Говь-Алтай | 114 | 54 | 17 | 158 | 0 | 636 |
| Завхан | 16 | 28 | 7 | 102 | 0 | 548 |
| Увс | 47 | 269 | 48 | 96 | 0 | 511 |
| Ховд | 9 | 200 | 81 | 353 | 0 | 435 |
| **Хангайн бүс** | **268** | **1 563** | **368** | **1 479** | **81** | **6 529** |
| Архангай | 24 | 20 | 32 | 95 | 0 | 852 |
| Баянхонгор | 32 | 229 | 64 | 239 | 0 | 827 |
| Булган | 60 | 109 | 72 | 272 | 0 | 433 |
| Орхон | 40 | 462 | 63 | 60 | 64 | 500 |
| Өвөрхангай | 93 | 331 | 20 | 0 | 17 | 1229 |
| Хөвсгөл | 19 | 412 | 117 | 813 | 0 | 1344 |
| **Төвийн бүс** | **378** | **1 118** | **374** | **1 061** | **90** | **5 11** |
| Говьсүмбэр | 25 | 66 | 39 | 43 | 0 | 439 |
| Дархан-Уул | 98 | 292 | 96 | 265 | 90 | 265 |
| Өмнөговь | 138 | 130 | 101 | 658 | 0 | 924 |
| Дорноговь | 34 | 45 | 29 | 95 | 0 | 1 328 |
| Дундговь | 5 | 15 | 15 | 0 | 0 | 115 |
| Сэлэнгэ | 39 | 252 | 88 | 0 | 0 | 352 |
| Төв | 39 | 318 | 6 | 0 | 0 | 1 588 |
| **Зүүн бүс** | **113** | **495** | **174** | **1069** | **22** | **2 563** |
| Дорнод | 39 | 34 | 100 | 495 | 22 | 913 |
| Сүхбаатар | 14 | 189 | 44 | 121 | 0 | 1 056 |
| Хэнтий | 60 | 272 | 30 | 453 | 0 | 594 |
| Улаанбаатар | 563 | 5 830 | 1 152 | 9 533 | 702 | 1 184 |

## 1.2.5. ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Монгол Улсын хэмжээнд 2024 онд хүүхэд хөгжлийн үйлчилгээнд давхардсан тоогоор нийт **376,299** хүүхэд хамрагдсан бөгөөд үүний 54.5 хувь эмэгтэй, 45.5 хувь нь эрэгтэй, 03 хувь буюу 1066 нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна.

*Зураг 1.48. Хүүхдийн хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо, үйлчилгээ үзүүлсэн байгууллагаар, 2024 он*




*Зураг 1.49. Хүүхдийн хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо, үйлчилгээний төрлөөр, хувиар, 2024 он*



*Хүснэгт 1.11. Хүүхдийн хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо, үйлчилгээ үзүүлсэн байгууллагаар, бүс, аймаг, дүүргээр, 2024 он*

| Аймаг/нийслэл | Нийт | Хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэгч байгууллага | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Хүүхдийн ордон | Сургууль | Хөгжлийн төв | Хүүхдийн театр | Бусад |
| **УЛСЫН ДҮН** | **376 299** | **42 270** | **172 603** | **26 736** | **23 868** | **110 822** |
| **Баруун бүс** | **36 386** | **4 836** | **21 557** | **3 975** | **0** | **6 018** |
| Баян-Өлгий | 13 356 | 2 014 | 5 482 | 2 625 | 0 | 3 235 |
| Говь-Алтай | 4 570 | 675 | 3 442 | 31 | 0 | 422 |
| Завхан | 248 | 247 | 0 | 0 | 0 | 1 |
| Увс | 7 310 | 0 | 4 124 | 826 | 0 | 2 360 |
| Ховд | 10 902 | 1 900 | 8 509 | 493 | 0 | 0 |
| **Хангайн бүс** | **50 997** | **5 072** | **25 785** | **3 539** | **11 957** | **4 644** |
| Архангай | 634 | 0 | 0 | 0 | 0 | 634 |
| Баянхонгор | 13 702 | 1 435 | 289 | 128 | 11 850 | 0 |
| Булган | 1 340 | 0 | 0 | 169 | 0 | 1 171 |
| Орхон | 9 296 | 1 369 | 7 238 | 283 | 92 | 314 |
| Өвөрхангай | 14 249 | 797 | 8 310 | 2 955 | 15 | 2 172 |
| Хөвсгөл | 11 776 | 1 471 | 9 948 | 4 | 0 | 353 |
| **Төвийн бүс** | **105 736** | **31 469** | **43 601** | **3 759** | **11 476** | **15 431** |
| Говьсүмбэр | 215 | 0 | 46 | 169 | 0 | |
| Дархан-Уул | 9 297 | 5 317 | 0 | 0 | 0 | 3 980 |
| Өмнөговь | 4 705 | 579 | 3 042 | 374 | 0 | 710 |
| Дорноговь | 5 819 | 374 | 2 786 | 876 | 328 | 1 455 |
| Дундговь | 3 270 | 573 | 428 | 847 | 0 | 1 422 |
| Сэлэнгэ | 23 010 | 478 | 22 337 | 195 | 0 | 0 |
| Төв | 59 420 | 24 148 | 14 962 | 1 298 | 11 148 | 7 864 |
| **Зүүн бүс** | **29 910** | **0** | **12 431** | **8 408** | **0** | **9 071** |
| Дорнод | 7 992 | 0 | 0 | 7 992 | 0 | 0 |
| Сүхбаатар | 7 565 | 0 | 5 565 | 0 | 0 | 2 000 |
| Хэнтий | 14 353 | 0 | 6 866 | 416 | 0 | 7 071 |
| **Улаанбаатар** | **563** | **5 830** | **1 152** | **9 533** | **702** | **1 184** |
| Багануур | 2 725 | 0 | 2 438 | 7 | 0 | 280 |
| Багахангай | 2 529 | 0 | 689 | 0 | 0 | 1 840 |
| Баянгол | 2 692 | 0 | 0 | 0 | 0 | 2 692 |
| Баянзүрх | 34 145 | 108 | 32 231 | 0 | 0 | 1 806 |
| Налайх | 10 096 | 785 | 23 | 7 | 355 | 8 926 |
| Сонгинохайрхан | 43 470 | 0 | 24 698 | 2 464 | 1 | 1 6307 |
| Сүхбаатар | 260 | 0 | 83 | 0 | 79 | 98 |
| Хан-Уул | 51 639 | 0 | 8 078 | 0 | 0 | 43 561 |
| Чингэлтэй | 5 714 | 0 | 989 | 4 577 | 0 | 148 |

# АХМАД НАСТАН 2024 он



**11.8%**
Нийт хүн амд эзлэх хувь

Эрэгтэй **128 439**

Эмэгтэй **277 813**

## насны бүлэг, хүйсээр




**ГАНЦ БИЕЭР ӨРХ ҮҮСГЭН АМЬДАРЧ БАЙГАА АХМАД НАСТАН**
**39 628**

**АХМАД НАСТАН АЖИЛЛАГЧИД**
**90 956**

**ӨНДӨР НАСТНЫ ТЭТГЭВЭР АВАГЧ**
**414 297**

# 1.3 АХМАД НАСТНЫ ҮЗҮҮЛЭЛТ

## 1.3.1 АХМАД НАСТНЫ ТОО, ХҮН АМ ЗҮЙН ЗАРИМ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2023 онд 60-аас дээш насны хүн амын тоо 1.1 тэрбум байсан бол 2030 онд 1.4 тэрбум (16.5%), 2050 он гэхэд энэ тоо хоёр дахин өсөж 2.1 тэрбум (21.5%) хүн амд хүрэх төлөвтэй бөгөөд 2050 он гэхэд 5 хүн тутмын нэг нь 60, түүнээс дээш насны хүн ам болохоор байна.

Монгол Улсын хувьд 60, түүнээс дээш насны хүн ам нийт хүн амд эзлэх хувь 2024 онд 9.8 хувь байсан бол 2030 онд 10.6 хувь, 2050 он гэхэд нийт хүн амын 17.3 хувьтай тэнцэх магадлалтай байна.

*Зураг 1.50. Монгол Улсын хүн амын хэтийн тооцоо, мянган хүн, эзлэх хувиар, 2020-2050 он*




Эх сурвалж: МУ-ын харьяат хүн амын хувьд тооцсон хүн амын тоо, дунд хувилбар 2Б, ҮСХ, 2024 он

Монгол Улсын нийт хүн ам 2024 онд 3.5 сая хүн болж, 2020 онтой харьцуулахад 7.5 хувиар өссөн бол харин ахмад настан 406.3 мянган болж 30.9 хувиар нэмэгдсэн бөгөөд нийт хүн амын нэмэгдсэн бөгөөд нийт хүн амын 11.8 хувийг эзэлж байна.

**Ахмад настан гэж** Монгол улсын Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу 60, түүнээс дээш эрэгтэй, 55, түүнээс дээш настай эмэгтэй хүнийг хамруулсан байна.

Нийт ахмад настны 2024 онд 128,439 буюу 31.6 хувь нь эрэгтэй, 277,813 буюу 68.4 хувь нь эмэгтэйчүүд байна. Нийт ахмад настнуудын 21.2 хувь нь 55-59, 32.4 хувь нь 60-64, 21.3 хувь нь 65-69, 25.1 хувь нь 70, түүнээс дээш насных байна. Нийт ахмад настны 47.6 хувь нь хотод, 52.4 хувь нь хөдөөд амьдарч байна.

*Зураг 1.51. Ахмад настны тоо, насны бүлэг, хүйсээр 2024 он*




*Зураг 1.52. Ахмад настны тоо, аймаг нийслэлээр, 2024 он*



Улсын хэмжээнд 2024 оноор дундаж наслалт 71.8 болжээ. Дундаж наслалтыг хүйсээр авч үзвэл эрэгтэй 67.9 нас, эмэгтэй 77.1 нас байна. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү 2000 онд 5.7 жил байсан бол 2024 онд 9.2 жил байна.

*Зураг 1.53. Хүн амын дундаж наслалт, хамгийн их болон бага улс орнууд, 2024 он*




Эх сурвалж: https://www.worldometers.info/demographics/life-expectancy/

## 1.3.2. АХМАД НАСТНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Монгол улсын хэмжээнд 2024 оны байдлаар нийт ажиллагчдын тоо 1,355,666 байгаа бөгөөд үүний 90,956 буюу 6.7 хувь нь ахмад настай ажиллагчид байгаа нь 2020 онтой харьцуулахад 26 хувиар өссөн үзүүлэлт юм.

*Зураг 1.54. Ахмад настан ажиллагчдын тоо, хүйс, насны бүлгээр, 2024 он*




Ахмад настан ажиллагчдын тоо 30,510 буюу 33.5 хувь нь эрэгтэй, 60,086 буюу 66.5 хувь эмэгтэй байна. Ахмад ажиллагчдыг насны бүлгээр авч үзвэл 33,891 буюу 37.4 хувь нь 55-59, 36,519 буюу 40.3 хувь нь 60-64, 14465 буюу 15.9 хувь 65-69, 5721 буюу 6.4 хувь нь 70, түүнээс дээш насных байна.

Нийт ахмад ажиллагчдын хамгийн их буюу 34.4 хувь Хөдөө аж ахуйн мэргэшсэн ажил мэргэжлээр болон Хөдөө аж ахуйн салбарт (35.0%) ажиллаж байна. Сарын дундаж цалингаар авч үзвэл, цалин хөлстэй ажиллагчид 1227.9 мянган төгрөг, орлого олж буй ажиллагчдын хувьд 583.4 мянган төгрөг байна.

*Зураг 1.55. Ахмад настан ажиллагчдын тоо, ажил мэргэжлээр, 2024 он*



*Зураг 1.56. Ахмад настан ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагаагаар, 2024 он*




## 1.3.3. АХМАД НАСТНЫ ТЭТГЭВЭР

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлд зааснаар тэтгэврийн даатгалын шимтгэлийг 25-аас доошгүй жил (2025 онд 22 ба жил бүр 3 сараар нэмэгдэж 2037 онд 25 жил болно) төлсөн 60 насанд хүрсэн эрэгтэй, 55 насанд хүрсэн эмэгтэй, мөн нийтдээ 20-иос доошгүй жил шимтгэл төлсөн 65 насанд хүрсэн даатгуулагч ердийн нөхцөлөөр тус тус өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрхтэй.

Түүнчлэн, 10-20 хүртэл жил шимтгэл төлсөн 65 насанд хүрсэн даатгуулагч тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгон авах эрхтэй.

Нийгмийн даатгалын сангаас нийт тэтгэвэр авагчдын тоо 2024 онд 531.8 мянга болж, үүнээс 414.3 мянга (77.9 хувь) нь өндөр насны тэтгэвэр авагчид байна. Олгосон нийт тэтгэврийн 77.9 хувь нь өндөр насны тэтгэвэрт ногдож байна. Сарын дундаж тэтгэврийн хэмжээ 787,510.6 төгрөг байна.

*Зураг 1.57. Өндөр насны тэтгэвэр авагчийн тоо, дундаж тэтгэвэр, 2020-2024 он*




*Зураг 1.58. Өндөр насны тэтгэвэр авагчийн тоо, бүс, аймаг нийслэлээр, 2024 он*






СТАТИСТИК 2024

## 1.3.4. АХМАД НАСТНЫ ЭРҮҮЛ МЭНД

Ахмад настнууд дунд зүрх, судасны өвчин 35.1%, хоол боловсруулах эрхтний өвчин 12.6%, шээс-бэлгийн тогтолцооны өвчин 10.3%, мэдрэлийн тогтолцооны өвчин 8.7% дэлгэрсэн байдаг. Сэтгэл зүйн хувьд 80% орчим нь байнгын санаа зовнил, нойргүйдэлтэй буюу стресс, ганцаардалд ордог, 20.3% нь сэтгэлээр унасан, 17.4% нь ганцаардмал байдлыг илэрхийлсэн байна.

*Хүснэгт 1.12. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн өвчний бүтэц, төрлөөр*

| ӨВЧНИЙ ТӨРӨЛ | Ахмадууд дунд |
|---|---|
| • Зүрх судасны | 35.1% |
| • Хоол боловсруулах | 12.6% |
| • Шээс ялгаруулах | 10.3% |
| • Мэдрэлийн | 8.7% |

Ахмадуудын 12,000 орчим нь эрүүл мэндийн хөгжлийн төвөөр “Хөгжлийн бэрхшээлтэй” хэмээн бүртгэгдсэн. Ахмад настнуудын 85.5 хувь нь нэг буюу түүнээс дээш өвчнөөр өвдсөн бөгөөд эмийн хөнгөлөлт, урьдчилан сэргийлэх үзлэг, сэтгэлзүйн дэмжлэгт бүрэн хамрагдаж чадахгүй хэвээр байна. Жил бүр гэрээр халамж, эрүүл мэндийн үзлэгт хамруулах, шинэ дэвшилтэт технологи бүхий эрүүл мэндийн үйлчилгээ нэвтрүүлэх амлалт хэдий ч хэрэгжилтийн түвшин хангалтгүй нийтлэг хэвээр байна.

# ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, 2024 ОН




ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ ХҮН
**89,594** 12.1%

ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ИРГЭД
**16,175** 18.1%

**ЭРЭГТЭЙ**
**61,728** 57.2%

**ЭМЭГТЭЙ**
**46,176** 42.8%

| Насны бүлэг | Эрэгтэй | Эмэгтэй |
|---|---|---|
| 0-14 нас | 6165 | 3959 |
| 15-64 нас | 51306 | 38288 |
| 65+, өндөр настан | 4256 | 3930 |



## 1.4 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, тэгш байдлыг хангах асуудал нь сүүлийн жилүүдэд төрийн бодлого болон олон нийтийн анхаарлын тэргүүлэх чиглэлүүдийн нэг болсон байна. 2024 оны байдлаар төрийн байгууллагууд, олон улсын хамтын ажиллагааны байгууллагууд болон иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаа өргөжин хөгжиж, бодлогын шинэчлэл болон дэмжих үйл ажиллагаа идэвхтэй хэрэгжиж байна. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхцөл байдлыг судалж шинжлэх, улмаар нотолгоонд суурилсан шийдэл боловсруулах суурийг бүрдүүлж байна.

Энэхүү танилцуулгын зорилго нь 2024 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, бүтэц, насны ангилал, бэрхшээлийн хэлбэр ба шалтгаан, бүс нутгийн ялгаа, хөдөлмөр эрхлэлтийн түвшин, төрийн албанд ажиллаж буй иргэдийн талаарх статистик мэдээлэлд тулгуурлан өнөөгийн нөхцөл байдлыг харуулах зорилготой юм. Үүнээс гадна, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг хариуцдаг салбарын онцлог шинж, нийгмийн хандлага, бодлого болон үйлчилгээний хүртээмж, технологи, инновацын чиг хандлагыг нарийвчлан шинжилж, тулгамдсан асуудлыг тодорхойлохын зэрэгцээ цаашдын хөгжлийн чиг хандлагад үндэслэсэн нэгдсэн дүгнэлт гаргахад энэхүү танилцуулга чиглэнэ.



### 1.4.1. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ

2024 онд Хөгжлийн бэрхшээлтэй 107,904 иргэд байгаагаас 61,728 эрэгтэй буюу 57.2% байна. Харин 46,176 эмэгтэй буюу 42.8%-ийг эзэлж байна. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд эрэгтэйчүүдийн эзлэх хувь эмэгтэйчүүдээс илүү байгааг харуулж байна.

*Зураг 1.59. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, хүйсээр, байршлаар, 2024 он*



*Хүснэгт 1.13. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт, 2024 он*

| ҮЗҮҮЛЭЛТ | Хүн | Хувь |
|---|---|---|
| 15 ба түүнээс дээш насныхан | 97,780 | 90.6% |
| Хөдөлмөрийн насныхан (15-64 нас) | 89,594 | 12.1% |
| Нийт хөдөлмөр эрхэлдэг иргэд | 16,175 | 14.9% |
| Төрийн албанд ажилладаг | 5,853 | 36.2% |

Хөгжлийн бэрхшээлийн төрлөөр нь авч үзвэл 21,215 буюу 19.7 хувь нь сэтгэцийн, 19,444 буюу 18.0 хувь нь хөдөлгөөний, 1,498 хүн буюу 10.7 хувь нь харааны, 7,561 хүн буюу 7.0 хувь нь сонсголын, 3,482 хүн буюу 3.2 хувь нь хэл ярианы, 7,034 хүн буюу 6.5 хувь нь олон төрлийн буюу хавсарсан, 37,670 буюу 34.9 хувь нь бусад төрлийн хөгжлийн бэрхшээлтэй тус тус байна.

*Зураг 1.60. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр, 2024 он*



2024 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн насны бүтцийг авч үзвэл нийт 107,904 хүнээс 15-64 насны 89,594 хүн буюу 83%-ийг бүрдүүлж, хамгийн өндөр хувийг эзэлж байна. Харин 0-14 насны хүүхэд 10,124 хүн буюу 9%, 65-аас дээш насны өндөр настан 8,186 хүн буюу 8%-ийг тус тус эзэлж байна.

Энэхүү мэдээлэл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн насны бүтэц, насны онцлогт суурилсан дэмжлэг, үйлчилгээний чиглэл тодорхойлоход чухал ач холбогдолтой.

*Зураг 1.61. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, насны бүлгээр*




## 1.4.2. Хөдөлмөр эрхлэлт ба төрийн албанд ажиллаж буй иргэд

2024 оны байдлаар нийт 16,175 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд үүнээс 5,853 нь төрийн албанд ажиллаж, байгаа нь нийт ажиллаж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 36.2%-ийг бүрдүүлж байна. Энэ нь хөдөлмөр эрхлэлтийн квотын тогтолцоо тодорхой хэмжээнд хэрэгжиж, төрийн байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого баримталж байгааг илтгэж байна. Гэсэн хэдий ч Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн албан болон албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар нарийвчилсан, ангилсан статистик мэдээлэл хязгаарлагдмал хэвээр байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2-т "Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 4 хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулах" гэж заасан.

*Хүснэгт 1.14. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, аймаг, нийслэлээр, 2024 он*

| Аймаг, нийслэл | Бүгд | Эмэгтэй | Байршил | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Аймаг, нийслэл | Тосгон | Сум | Хөдөө |
| **УЛСЫН ДҮН** | 107,904 | 46,176 | 65752 | 1443 | 19695 | 21014 |
| **Баруун бүс** | 17,705 | 7,670 | 7368 | 87 | 3867 | 6383 |
| Баян-Өлгий | 4,309 | 2,007 | 2041 | 12 | 836 | 1420 |
| Говь-Алтай | 2,574 | 1,063 | 674 | 66 | 615 | 1219 |
| Завхан | 3,298 | 1,427 | 895 | 0 | 937 | 1466 |
| Увс | 4,415 | 1,873 | 2252 | 0 | 786 | 1377 |
| Ховд | 3,109 | 1,300 | 1506 | 9 | 693 | 901 |
| **Хангайн бүс** | 24,084 | 10,234 | 10717 | 330 | 5640 | 7397 |
| Архангай | 3,632 | 1,486 | 1025 | 0 | 791 | 1816 |
| Баянхонгор | 3,826 | 1,655 | 1857 | 73 | 486 | 1410 |
| Булган | 2,233 | 886 | 21 | 100 | 1327 | 785 |
| Орхон | 4,210 | 1,796 | 1651 | 0 | 1238 | 1321 |
| Өвөрхангай | 5,733 | 2,440 | 1868 | 157 | 1692 | 2016 |
| Хөвсгөл | 4,450 | 1,971 | 4295 | 0 | 106 | 49 |
| **Төвийн бүс** | 21,100 | 8,873 | 9144 | 788 | 6845 | 4323 |
| Говьсүмбэр | 578 | 244 | 0 | 6 | 455 | 117 |
| Дархан-Уул | 5,034 | 2,056 | 3998 | 0 | 844 | 192 |
| Өмнөговь | 3,040 | 1,265 | 1254 | 72 | 967 | 747 |
| Дорноговь | 1,868 | 813 | 675 | 0 | 402 | 791 |
| Дундговь | 2,487 | 1,100 | 1323 | 0 | 664 | 500 |
| Сэлэнгэ | 4,713 | 2,030 | 1177 | 686 | 2173 | 677 |
| Төв | 3,380 | 1,365 | 717 | 24 | 1340 | 1299 |
| **Зүүн бүс** | 10,661 | 4,470 | 4282 | 230 | 3342 | 2807 |
| Дорнод | 4,248 | 1,835 | 2098 | 0 | 937 | 1213 |
| Сүхбаатар | 2,965 | 1,225 | 1203 | 0 | 869 | 893 |
| Хэнтий | 3,448 | 1,410 | 981 | 230 | 1536 | 701 |
| **Улаанбаатар** | 34,354 | 14,929 | 34241 | 8 | 1 | 104 |

# ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ



## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ, 2024 он

| | |
|---|---|
| Ажиллах хүчний оролцооны түвшин **61.3%** | Хөдөлмөр эрхлэлтийн түвшин **57.6%** |
| Ажилгүйдлийн түвүин **61.3%** | Хөдөлмөрийн дутуу ашиглалтын түвшин **61.3%** |

### АЖИЛЛАГЧДЫН **САРЫН ГОЛЧ** ЦАЛИН /мянган төгрөг/

# 1,911.4₮



### АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦОО, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН

**01** НИЙТ АЖИЛЛАХ ХҮЧ **1,441,090**

**02** НИЙТ АЖИЛЛАГЧ **1,355,666**

**03** АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУР **911,690**

**04** АЖИЛГҮЙ ХҮН **86,423**

### АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХҮЙСЭЭР



# БҮЛЭГ 2. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ

## 2.1 ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ ХҮН АМ

2024 оны байдлаар Монгол Улсын 15 ба түүнээс дээш насны 2.3 сая хүн байна. Хөдөлмөрийн насны хүн амын 1.428.8 мянган хүн буюу 61.3% нь хөдөлмөрийн зах зээлд оролцож байгаа ажиллах хүч байгаа бол 849.6 мянган хүн 37.8% нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна.

*Зураг 2.1. Хөдөлмөрийн насны хүн амын бүтэц, мянган хүнээр, 2021-2024 он, улирлаар*




*Зураг 2.2. 15 ба түүнээс дээш насны ажиллагчид. 2021-2024 он*



## 2.2. АЖИЛЛАГЧИД

*Зураг 2.3. Ажиллагчид насны бүлгээр, 2024 он*




*Зураг 2.4. Ажиллагчдын хөдөлмөр эрхлэлтийн түвшин, аймаг, нийслэлээр*




### 2.2.1. АЖИЛЛАГЧДЫН АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ

Ажиллагчдыг эрхэлж буй ажил мэргэжлээр нь авч үзвэл, 314.6 мянган хүн буюу 23.2% нь хөдөө аж ахуй, ой, загас агнуурын салбарт, 244.9 мянган хүн 18.1% нь мэргэжилтэн, 212.6 мянган хүн 15.7% нь худалдаа, үйлчилгээний ажил, мэргэжлээр тус тус ажиллаж байна.

*Зураг 2.5. Ажиллагчдын тоо, ажил мэргэжлийн ангилалаар, 2024 он*




## 2.2.2. АЖИЛЛАГЧИД, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТӨРЛӨӨР

Ажиллагчдыг ажиллаж буй байгууллагынх нь төрлөөр авч үзвэл, 498.4 мянган хүн 36.8% нь хувийн аж ахуйн нэгж байгууллагад, 302.3 мянган хүн 22.3% нь өрхийн аж ахуйд, 259.8 мянган хүн 19.2% нь төсөвт байгууллагад ажиллаж байгаа бол 183.0 мянган хүн 13.5% нь хувийн бизнес эрхлэгч буюу хувь хүн, иргэд байна.

*Хүснэгт 2.1. Ажиллагчид аж ахуйн нэгж, байгууллагын төрлөөр, хүйсээр*

| Үзүүлэлтүүд | Нийт дүн | | Эрэгтэй | | Эмэгтэй | |
|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Хувь | Тоо | Хувь | Тоо | Хувь |
| Улсын дүн | 1,355,666 | 100% | 738,807 | 55% | 614,581 | 45% |
| Төрийн өмчит аж ахуйн оролцоотой үйлдвэрийн газар | 28,603 | 2.1% | 19,164 | 2.6% | 9,439 | 1.5% |
| Орон нутгийн өмчит аж ахуйн оролцоотой үйлдвэрийн газар | 17,771 | 1.3% | 11,060 | 1.5% | 6,711 | 1.1% |
| Төсөвт байгууллага | 259,773 | 19.2% | 93,404 | 12.6% | 166,369 | 27.1% |
| Төрийн бус байгууллага (сүм, хийд) | 10,752 | 0.8% | 6,253 | 0.8% | 4,499 | 0.7% |
| ОУ-ын байгууллага, суурин төлөөлөгчийн газар | 1,264 | 0.1% | 722 | 0.1% | 542 | 0.1% |
| Хувьцаат компани | 48,596 | 3.6% | 27,754 | 3.8% | 20,842 | 3.4% |
| Хувийн аж ахуйн нэгж байгууллага | 498,444 | 36.8% | 296,890 | 40.2% | 201,554 | 32.8% |
| Хувийн бизнес буюу хувь хүн (ферм болон ХХК биш) | 182,959 | 13.5% | 104,868 | 14.2% | 78 091 | 12.7% |
| Өрхийн аж ахуй | 302,255 | 22.3% | 177,503 | 24.0% | 124,752 | 20.3% |

## 2.3. ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТ

2024 онд хөдөлмөрийн дутуу ашиглалт нийт 88.2 мянган хүн байна. Үүнээс 75.4 мянга буюу 85.5% нь ажилгүйчүүд, 10.9 мянга буюу 12.4% нь боломжит ажиллах хүч, харин 1.9 мянга буюу 2.1% нь цаг хугацааны хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид байна. Түүнчлэн хөдөлмөрийн дутуу ашиглалтын хэмжээ өмнөх оны мөн үеэс 24.8 мянган хүнээр буюу 21.9%-иар буурсан нь ажиглагдаж байна.

*Зураг 2.6. Хөдөлмөрийн дутуу ашиглалт, хувиар, 2021-2024 он*




*Зураг 2.7. Хөдөлмөрийн дутуу ашиглалтын түвшин, насны бүлгээр, хувиар*




*Зураг 2.8. Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч, насны бүлгээр*



*Зураг 2.9. Ажил хайгч иргэдийн тоо, хүйсээр, аймгаар, 2024 он*




## 2.4. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД

*Зураг 2.10. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо, хүйсээр, аймгаар, 2024 он*






СТАТИСТИК 2024

*Зураг 2.11. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо, насны ангиллаар, бүсээр*




Бүртгэлтэй ажилгүй иргэдийг насны бүлгээр авч үзвэл, 1.5 мянга (14.6 хувь) нь 15-24 насны, 3.3 мянга (32.8 хувь) нь 25-34 насны, 2.9 мянга (29.4 хувь) нь 35-44 насны, 1.8 мянга (17.6 хувь) нь 45-54 насны, 0.5 мянга (5.6 хувь) нь 55, түүнээс дээш насныхан байна.

*Зураг 2.12. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, бүсээр*




Боловсролын түвшнээр авч үзвэл, 1.1 хувь нь боловсролгүй, 4.2 хувь нь бага, 8.2 хувь нь суурь, 44.2 хувь нь бүрэн дунд, 7.6 хувь нь техникийн болон мэргэжлийн, 4.6 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 28.2 хувь нь дипломын дээд болон бакалавр, 1.9 хувь нь магистр, түүнээс дээш түвшний боловсролтой байна. Бүрэн дунд боловсролтой бүртгэлтэй ажилгүй иргэдийн 1,357 нь баруун бүсэд, 1,092 нь зүүн бүсэд, 1,057 нь Улаанбаатар хотод, 908 нь бусад бүсэд бүртгүүлсэн байна.

## 2.5. АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА

2024 оны байдлаар 112,390 ажлын байрны захиалга ирсэн бөгөөд өмнөх оноос 27,520 буюу 32.4 хувиар өссөн байна. Нийт ажлын байрны захиалгын 44.2 хувь нь Улаанбаатар хот, 42.8 хувь нь төвийн бүс, 9.4 хувь нь зүүн бүс, 3.1 хувь баруун бүс, 2.2 хувь нь хангайн бүсэд бүртгэгдсэн байна.

*Зураг 2.13. Ажлын байрны захиалга, бүсээр, эзлэх хувиар*




*Зураг 2.14. Ажлын байрны захиалга, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, 2024 он*



*Зураг 2.15. Ажлын байрны захиалга, ажил мэргэжлийн ангиллаар*




Ажлын байрны захиалгын бүтцийг ажил мэргэжлийн ангиллаар авч үзвэл энгийн ажил мэргэжил 27.5%, мэргэжилтэн 18.4%, үйлдвэрлэл, барилга, гар урлалын ажилтан 14.0%, худалдаа үйлчилгээний ажилтан 10.3%, суурин төхөөрөмжийн операторч 8.0%, хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан 7.3%, техникч болон туслах мэргэжилтэн 6.8%, менежер 3.4%, зэвсэгт хүчний ажил мэргэжил 2.4%, конторын ажилтан 1.9%-ийг тус тус эзэлж байна.

*Зураг 2.16. Ажлын байрны захиалга, өмчийн хэлбэрээр, бүсээр*




Ажлын байрны захиалгыг өмчийн хэлбэрээр авч үзэхэд 33.1 хувь нь төрийн өмчийн, 2.3 хувь нь орон нутгийн өмчийн, 56.0 хувь нь Монгол Улсын хувийн, үлдсэн нь төрийн болон орон нутгийн оролцоотой, хамтарсан болон гадаадын захиалга байна. Монгол Улсын хувийн өмчийн нийт 62,989 ажлын байрны захиалгын 3,535 нь баруун, 7,937 нь хангай, 11,156 нь төв, 3,222 нь зүүн бүсэд, харин 37,139 нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна.

## Зураг 2.17. Ажлын байрны захиалга, өмчийн хэлбэрээр, бүсээр




## Зураг 2.18. Ажлын байрны захиалга, өмчийн хэлбэрээр, бүсээр




## Зураг 2.19. Ажлын байрны захиалга, хариуцлагын хэлбэрээр, бүсээр




Хариуцлагын хэлбэрээр ажлын байрны захиалгыг харвал хувьцаат компани 4.0 хувь, хязгаарлагдмал хариуцлагатай компани 25.8 хувь, нөхөрлөл 0.3 хувь, хоршоо 0.9 хувь, төрийн өмчит үйлдвэрийн газар 20.2 хувь, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 0.7 хувь, төсөвт байгууллага 6.4 хувь, төрийн бус байгууллага 0.2 хувь, бусад 41.5 хувийг эзэлж байна.

## 2.6. АЖЛЫН БАЙРАНД ЗУУЧЛАГДСАН ИРГЭД

Ажилд зуучлагдсан иргэдийг бүсээр харвал 11.1 хувь нь зүүн бүс, 15.4 хувь баруун бүс, 20.8 хувь нь төвийн бүс, 24.5 хувь нь хангайн бүс, 28.2 хувь нь Улаанбаатар хотод байна.

*Зураг 2.20. Ажилд зуучлагдсан иргэд, бүсээр, эзлэх хувиар*




*Зураг 2.21. Ажилд зуучлагдсан иргэд, бүсээр, хүйсээр*




Ажилд зуучлагдсан иргэдийг хүйсээр авч үзвэл 16,763 буюу 50.1 хувь нь эмэгтэй, 16,722 буюу 49.9 хувь нь эрэгтэйчүүд эзэлж байна. Бүс тус бүрээр ажилд зуучлагдсан иргэдийн хүйсийн харьцааг харвал баруун бүсийн 53.4 хувь нь эрэгтэй, 46.6 хувь нь эмэгтэй, хангайн бүсийн 51.5 хувь

нь эрэгтэй, 48.5 хувь нь эмэгтэй, төвийн бүсийн 49.2 хувь нь эрэгтэй, 50.8 хувь нь эмэгтэй, зүүн бүсийн 55.4 хувь нь эрэгтэй, 44.6 хувь нь эмэгтэй, Улаанбаатар хотын 45.1 хувь нь эрэгтэй, 54.9 хувь нь эмэгтэй байна.

*Зураг 2.22. Ажилд зуучлагдсан иргэд, ажил мэргэжлийн ангиллаар*




Ажил мэргэжлийн ангиллаар энгийн ажил мэргэжил 32.9 хувь, мэргэжилтэн 17.0 хувь, үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан 10.6 хувь, ХАА, ой, загас агнуурын ажилтан 9.9 хувь, худалдаа, үйлчилгээний ажилтан 9.9 хувь, суурин тоноглол, машин механизмын операторч, угсрагч 6.5 хувь, техникч болон туслах/дэд мэргэжилтэн 5.2 хувь, менежер 3.5 хувь, зэвсэгт хүчний ажил, мэргэжил 2.2 хувь, контор, үйлчилгээний ажилтан 2.3 хувийг эзэлж байна.

*Зураг 2.23. Ажилд зуучлагдсан иргэд, ажил мэргэжлийн ангиллаар, хүйсээр*




СТАТИСТИК 2024

*Зураг 2.24. Ажилд зуучлагдсан иргэд, ажил мэргэжлийн ангиллаар, салбараар*




Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын хувьд хөдөө аж ахуйн салбарт ажилд зуучлагдсан иргэд хамгийн их хувийг буюу 19.6 хувийг эзэлж байна.

Харин боловсруулах үйлдвэрлэл 12.7 хувь, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал 10.5 хувь, уул уурхай олборлолт 9.0 хувь, усан хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа 7.9 хувь, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ 7.6 хувь, үлдсэн салбарууд нь 22.8 хувийг эзэлж байна.

*Зураг 2.25. Ажилд зуучлагдсан иргэд, өмчийн хэлбэрээр, бүсээр*




Ажилд зуучлагдсан иргэдийг насны бүлгээр авч үзвэл, 5,335 (15.9 хувь) нь 15-24 насны, 9,252 (27.6 хувь) нь 25-34 насны, 8,760 (26.2 хувь) нь 35-44 насны, 6,240 (18.6 хувь) нь 45-54 насны, 3,898 (11.7 хувь) нь 55, түүнээс дээш насныхан эзэлж байна.

*Зураг 2.25. Ажилд зуучлагдсан иргэд, өмчийн хэлбэрээр, бүсээр*



## 2.7. ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛД ОРСОН ИРГЭД

Улсын хэмжээнд 2024 онд нийт 31,882 ажлын шинэ байрыг бүртгэж тухайн ажлын байранд ажилд орсон иргэдийн мэдээллээр баталгаажуулсан байна. Нийт шинэ ажлын байрнаас, байнгын шинэ ажлын байр 20,876 буюу 65,5 хувь, улирлын шинэ ажлын байр 2,064 буюу 6,5 хувь, түр шинэ ажлын байр 8,942 буюу 28,0 хувийг тус тус эзэлж байна.

*Зураг 2.26. Шинэ ажлын байранд орсон иргэдийн тоо, ажил мэргэжлийн ангилал, ажлын байрны төрлөөр*




Шинэ ажлын байранд орсон иргэдийг ажил мэргэжлийн хувьд авч үзвэл энгийн ажил, мэргэжил 30.1 хувь, ХАА, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан 17.5 хувь, мэргэжилтэн 14.1 хувь, худалдаа, үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажил 11.6 хувь, үйлчилгээний ажилтан 9.5 хувь, Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч 5.9 хувь, техникч болон туслах/ дэд мэргэжилтэн 4.2 хувь, менежер 3.7 хувь, зэвсэгт хүчний ажил, мэргэжил 1.8 хувь, контор, үйлчилгээний ажилтан 1.6 хувь байна.

*Зураг 2.27. Шинэ ажлын байранд орсон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, ажлын байрны төрлөөр*



*Зураг 2.28. Шинэ ажлын байранд орсон иргэдийн тоо, бүсээр, ажлын байрны төрлөөр*




Шинэ ажлын байранд орсон иргэдийг байршлаар харвал 18.2 хувь нь баруун бүс, 25.7 хувь нь хангайн бүс, 21.1 хувь нь төвийн бүс, 10.5 хувь нь зүүн бүс, 24.5 хувь нь Улаанбаатар хотод байна. Дараах зурагт байнгын, улирлын болон түр шинэ ажлын байранд орсон иргэдийг бүсээр нь харуулсан.

## 2.8. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САН

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа нь Монгол Улсын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан “2024 онд хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, хөтөлбөр”, мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамж”-ийн хүрээнд хэрэгжүүлсэн.

*Зураг 2.29. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө, хамрагдсан хүн, хувиар, 2024 он*



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгө 4.7 хувь, Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө 12.6 хувь, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө 8.6 хувь, Түр ажлын байраар хангах болон ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө 21.6 хувиар буурсан бол Санхүүгийн дэмжлэгийн үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө 56.7 хувиар өссөн байна.

*Зураг 2.30. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө, үйл ажиллагааны төрлөөр, сая төгрөг 2023-2024 он.*




*Зураг 2.31. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө, үйл ажиллагааны төрлөөр, сая.төг*



## 2.9. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГО

2024 оны байдлаар үйлдвэрлэлийн осол хурц, хордлогод нийт 808 хүн өртөж, үүнээс 87 хүн нас барч, 722 хүн бэртэж, гэмтсэн байна. Нийт осолд нас баралтын эзлэх хувь 10,7 хувь байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлийн осол хурц хордлогод өртсөн хүний тоо 401 буюу 2 дахин өссөн байна.

*Зураг 2.32. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн иргэд, бүсээр*




Үйлдвэрлэлийн осол хурц, хордлогод өртсөн нийт иргэдийн 546 буюу 67.5 хувь нь эрэгтэйчүүд, 263 буюу 32.5 хувь нь эмэгтэйчүүд байна.

Нийт ослын тохиолдлын дийлэнх тохиолдлын 15.7 хувь нь уул уурхай, олборлолт, 13.7 хувь нь төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал, 13.2 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбаруудад гарсан байна.

*Зураг 2.33. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн иргэд, хүйсээр, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар*



## 2.10. ГАДААДАД АЖИЛЛАХ ХҮЧ ИЛГЭЭХ, АВАХ

*Зураг 2.34. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, бүсээр*




2024 оны байдлаар гадаадын 104 улсын 8,024 иргэн хөдөлмөрийн гэрээгээр Монгол Улсад ажиллаж байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 1,542 хүнээр буюу 23.8 хувиар өссөн байна. Ажиллаж буй гадаадын иргэдийн 6,779 буюу 84.5 хувь нь эрэгтэй, 1,245 буюу 15.5 хувь нь эмэгтэй байна.

Мөн 44.3 хувь нь Улаанбаатар хотод, 37.4 хувь нь төвийн бүсэд, 12.5 хувь нь зүүн бүсэд, 3.3 хувь нь баруун бүсэд, 2.5 хувь нь хангайн бүсэд ажиллаж байна. Харин иргэншлийн хувьд нийт гадаадын иргэдийн 57.8 хувь нь Хятад, 7.6 хувь нь Вьетнам, 5.5 хувь нь Филиппин, 3.9 хувь нь ОХУ, 3.2 хувь нь АНУ, 2.8 хувь нь Өмнөд Солонгос, 2.9 хувь нь Энэтхэгийн иргэн бөгөөд үлдсэн 15.8 хувь нь бусад улсын иргэн байна.

*Зураг 2.35. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, хүйсээр*



*Зураг 2.36. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд,эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, хүйсээр*



*Зураг 2.37. Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад зуучлагдсан иргэд, хүйсээр*




*Зураг 2.38. Гадаад улсад Хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар зуучлагдсан хүний тоо, улсаар, 2021-2024 он*




2024 оны байдлаар 892 иргэн хөдөлмөрийн гэрээгээр гадаадад ажилд зуучлагдсан бөгөөд өмнөх улирлаас 69 буюу 7.2 хувиар буурсан байна.

Гадаадад ажилд зуучлагдсан иргэдийн 722 (80.9 хувь) нь Өмнөд Солонгос, 170 (19.1 хувь) нь Япон улсад зуучлагдсан. Ажилд зуучлагдсан иргэдийн 585 (65.6 хувь) нь эрэгтэйчүүд, 307 (34.4 хувь) нь эмэгтэйчүүд байна. Өмнөд Солонгос улсад зуучлагдсан иргэдийн 520 нь эрэгтэй, 202 нь эрэгтэй бол Япон улсад зуучлагдсан иргэдийн 65 нь эрэгтэй, 105 нь эмэгтэй байна.

# НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЗҮҮЛЭЛТ



# НИИГМИИН ДААТГАЛЫН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ, 2024 он

## УЛСЫН ДҮН

НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИЙН ТОО

**1,136,930**

559,178
Эрэгтэй 49.17%

577,752
Эмэгтэй 50.83%

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТӨСӨВ

- Нийгмийн даатгалын сангийн орлого 5,609.7 тэрбум төгрөг
- Тэтгэврийн даатгалын сангийн орлого 4,724.9 тэрбум төгрөг
- УЛСЫН ТӨСВИЙН ТАТААС 1,174.9 тэрбум төгрөг
- Нийгмийн даатгалын сангийн зарлага 5,107.2 тэрбум төгрөг
- Тэтгэврийн даатгалын сангийн зарлага 4,666.5 тэрбум төгрөг

| НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИЙН ТОО | АЛБАН ЖУРМЫН ДААТГУУЛАГЧИЙН ТОО | САЙН ДУРЫН ДААТГУУЛАГЧИЙН ТОО | МАЛЧИН ДААТГУУЛАГЧИЙН ТОО |
|---|---|---|---|
| 1,136,930 | 996,769 | 140,161 | 53,772 |
| | 87.7% | 12.3% | 4.7% |

# БҮЛЭГ 3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

## 3.1. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН

Нийгмийн даатгалын сангийн нийт орлого 2024 онд **5.6 их наяд төгрөгт** хүрч, төлөвлөгөөний **95.2** хувийг биелүүлсэн байна. Орлогын бүтцээр харвал ажил олгогчийн төлсөн шимтгэл 95.9 хувь, даатгуулагчийн шимтгэл 91.6 хувь биелсэн нь нийт орлогын төлөвлөгөөнд нөлөөлжээ. Харин төрөөс болон улсын төсвөөс олгосон хөрөнгө **100 хувь** биелсэн нь орлогын тогтвортой байдлыг хангах чухал хүчин зүйл болсон байна.

*Зураг 3.1. Нийгмийн даатгалын сангийн орлого, төрлөөр, тэрбум төгрөг, 2024 он*




2024 онд нийгмийн даатгалын сангийн нийт зарлагын гүйцэтгэл **5.1 их наяд төгрөг** буюу төлөвлөгөөнөөс 1.6 хувиар бага биелэлттэй байна. Үүнээс тэтгэвэр, тэтгэмжийн зардал голлох хэсгийг эзэлж 98.4 хувийн биелэлттэй байсан бол бусад зардлын биелэлт 69.7 хувьтай гарсан нь зарим зардлын хэмнэлт болон төсвийн үр ашигтай зарцуулалтын үр дүнг илтгэж байна.

*Зураг 3.2. Нийгмийн даатгалын сангийн зарлага, төрлөөр, тэрбум төгрөг, 2024 он*




2024 онд нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага нь нийслэлд орлого 3.68 их наяд төгрөг буюу **нийт орлогын 65.6%,** зарлага 2.44 их наяд төгрөг буюу **нийт зарлагын 47.7%** төвлөрсөн бол бусад бүсүүдэд орлого бага (Баруун 6.3%, Хангайн 10.3%, Төвийн 13.5%, Зүүн 4.3%)

*Зураг 3.3. Нийгмийн даатгалын сангийн нийт орлого, зарлагын эзлэх хувь, бүсээр, 2024 он*



## 3.1.1. ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН САН

2024 онд тэтгэврийн даатгалын сангийн нийт орлого 4.74 их наяд төгрөг болж, төлөвлөгөөний 92.8 хувийн биелэлттэй гарсан байна. Орлогын бүтэц дотор ажил олгогчийн (90.6%) болон даатгуулагчийн (90.1%) шимтгэлийн орлого төлөвлөгөөнөөс бага биелсэн бол төрөөс болон улсын төсвөөс олгосон хөрөнгө бүрэн биелэлттэй байна. Бусад орлого төлөвлөснөөс давсан үзүүлэлттэй гарч, нэмэлт эх үүсвэрийн орлого нэмэгдснийг харуулж байна.

*Зураг 3.4. Тэтгэврийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, биелэлт хувь, тэрбум төгрөг, 2024 он*




2024 онд Тэтгэврийн даатгалын сангийн нийт зарлага 4.67 их наяд төгрөг болж, төлөвлөгөөний 98.4 хувийн биелэлттэй гарсан байна. Үүнээс тэтгэвэр, тэтгэмж, бусад зардлын гүйцэтгэл 98.4 хувьтай биелсэн бол бусад зарлага харьцангуй бага хэмжээгээр буюу төлөвлөгөөнөөс доогуур буюу 67.2 хувийн биелэлттэй гарсан нь зардлын хэмнэлттэй зарцуулалтыг илтгэж байна.

*Зураг 3.5. Тэтгэврийн даатгалын сангийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл, биелэлт хувь, тэрбум төгрөг, 2024 он*




2021–2024 онд Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчийн нийт тоо 459.7 мянгаас 531.8 мянга болж 15.7%-аар өссөн байна. Тэдний дотор өндөр насны тэтгэвэр авагчид 17.3%-аар, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр 8.7%-аар, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 10.8%-аар, цэргийн тэтгэвэр 15.3%-аар нэмэгдсэн нь сангийн зарцуулалт болон нийгмийн хамгааллын хөтөлбөрийн үр нөлөөг тодотгож байна.

*Зураг 3.6. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчид, тэтгэврийн төрлөөр*




2024 онд Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авсан нийт 531,756 хүн байгаагаас Улаанбаатар хотод 227,314 хүн (42.7%), Хангайн бүсэд 107,053 хүн (20.1%), Төвийн бүсэд 90,239 хүн (17.0%), Баруун бүсэд 67,798

хүн (12.8%), Зүүн бүсэд 39,352 хүн (7.4%) төвлөрсөн байна. Зарцуулсан нийт хөрөнгө 4,708,172 сая төгрөг бөгөөд үүний 38.0%-ийг Улаанбаатар, 24.2%-ийг Хангайн, 20.0%-ийг Төвийн, 10.9%-ийг Баруун, 6.9%-ийг Зүүн бүсэд тус тус зарцуулсан нь нийслэлд төвлөрөл өндөр, бүс нутгийн нийгмийн даатгалд хамрагдалтын ялгааг харуулж байна.

*Зураг 3.7. Нийгмийн даатгалын сангаас зарцуулсан хөрөнгө, тэрбум, төгрөгөөр, 2024 он*




2024 онд дундаж тэтгэврийн хэмжээ өндөр насны тэтгэвэрт 787,511, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 591,549, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэрт 574,042 төгрөг тус тус байна. Эрэгтэйчүүдийн дундаж тэтгэвэр нь эмэгтэйчүүдээс өндөр байгаа нь хөдөлмөрийн оролцоо, ажилласан жил болон цалин хөлсний ялгаатай холбоотой байна.

*Зураг 3.8. Дундаж тэтгэврийн хэмжээ, төрлөөр, хүйсээр, 2024 он*



## 3.1.2. ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН САН

2024 онд Тэтгэмжийн даатгалын сангийн нийт орлого 382.4 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөө бүрэн биелсэн байна. Орлогын бүтцээр харвал ажил олгогчийн шимтгэлийн орлого 106.6 хувийн биелэлттэйгээр төлөвлөгөөнөөс давж биелсэн бол даатгуулагчийн шимтгэлийн орлого 97.0 хувьтай, төлөвлөгөөнөөс бага биелэлттэй байна. Харин төрөөс төлсөн шимтгэл болон бусад орлого төлөвлөгөөндөө нийцтэй, тогтвортой гүйцэтгэлтэй байна.

*Зураг 3.9. Тэтгэмжийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, биелэлт хувь,тэрбум төгрөг, 2024 он*




2024 онд Тэтгэмжийн даатгалын сангийн нийт зарлага **256.3 тэрбум төгрөг** болж, төлөвлөгөөний **97.7** хувьтай биелэлттэй гарсан байна. Үүнээс тэтгэмжийн зардлын гүйцэтгэл **97.7** хувь, бусад зарлага **67.4** хувьтай биелсэн нь үндсэн зардлын төлөвлөгөө тогтвортой биелсэн боловч бусад зардал төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй, зардлын хэмнэлт гарчээ.

*Зураг 3.10. Тэтгэмжийн даатгалын сангийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл, биелэлт хувь,тэрбум төгрөг, 2024 он*




## 3.1.3. ҮОМШӨ-НИЙ ДААТГАЛЫН САН

2024 онд ҮОМШӨ-ний (үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний) даатгалын сангийн нийт орлого **345.0 тэрбум төгрөг** болж, төлөвлөгөөний **127.5** хувьтай биелсэн байна. Орлогын бүтэц дотор ажил олгогчийн шимтгэлийн орлого 140.6 хувьтай биелж төлөвлөгөөнөөс давсан бол даатгуулагчийн шимтгэлийн орлого 75.0 хувьтай, бусад орлого 52.2 хувьтай буюу төлөвлөгөөнөөс доогуур биелсэн байна. Харин улсын төсвөөс олгосон хөрөнгө 100 хувьтай биелсэн нь сангийн орлогын тогтвортой байдлыг хангаж байна.

*Зураг 3.11. ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, биелэлт хувь, тэрбум төгрөг, 2024 он*




2024 онд ҮОМШӨ-ний даатгалын сангийн нийт зарлага 48.1 тэрбум төгрөг болж, төлөвлөгөөний 77.8 хувьтай биелсэн байна. Үүнээс тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын гүйцэтгэл 77.7 хувь, бусад зарлага 90.3 хувьтай биелсэн нь төлөвлөсөн хэмжээнээс бага зардал гарсан, өөрөөр хэлбэл сангийн хөрөнгө зарцуулалт үр ашигтай, хэмнэлттэй байсныг илтгэж байна.

*Зураг 3.12. ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл, биелэлт хувь, тэрбум төгрөг, 2024 он*




СТАТИСТИК 2024

## 3.1.4. АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САН

2024 онд Ажилгүйдлийн даатгалын сангийн нийт орлого **139.4 тэрбум төгрөгт** хүрч, төлөвлөгөөний биелэлт давсан үзүүлэлттэй гарсан байна. Орлогын бүтцийн хувьд даатгуулагчийн шимтгэлийн орлого 55.6 тэрбум төгрөгөөр, төлөвлөгөөнөөс давсан гүйцэтгэлтэй байсан бол ажил олгогчийн шимтгэлийн орлого 82.9 тэрбум төгрөг, төлөвлөсөн хэмжээнээс бага биелэлттэй байна. Харин бусад орлого төлөвлөгөөнөөс мэдэгдэхүйц өсөж, нэмэлт санхүүгийн эх үүсвэрийн бүрдэлт сайжирсан байна.

*Зураг 3.13. Ажилгүйдлийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, сая.төгрөг, 2024 он*




2024 онд Ажилгүйдлийн даатгалын сангийн нийт зарлага **136.3 тэрбум төгрөг** болж, төлөвлөгөөний биелэлт 110.8 хувь гарсан байна. Үүнээс тэтгэмжийн зардлын гүйцэтгэл 136.3 тэрбум төгрөг буюу төлөвлөгөөнөөс давсан бол бусад зарлага 10.5 сая төгрөг болж төлөвлөгөөнөөс бага биелсэн нь зарцуулалтын гол өсөлт тэтгэвэр, тэтгэмжийн өсөлттэй холбоотой байна.

*Зураг 3.14. Ажилгүйдлийн даатгалын сангийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл, сая.төгрөг, 2024 он*



## 3.2. НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД

2024 оны байдлаар Нийгмийн даатгалд даатгуулагчид 1,137.0 мянга болж өмнөх оны мөн үеэс 31.1 мянгаар өссөн байна.

*Зураг 3.15. Нийгмийн даатгалд даатгуулагчид*




### 3.2.1. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨГЧ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА

*Зураг 3.16. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч аж ахуй нэгж, байгууллага*



*Зураг 3.17. Нийгмийн даатгалд хамрагдсан даатгуулагчид, насны бүлэг, хүйсээр*




Нийгмийн даатгалд хамрагдсан даатгуулагчдын хувьд 35–39 насны бүлэгт эмэгтэйчүүдийн тоо хамгийн өндөр бөгөөд нийт даатгуулагчдын дийлэнхийг 20–44 насны хөдөлмөрийн идэвхтэй насны хүн ам эзэлж байна.

*Зураг 3.18. Нийгмийн даатгалд хамрагдсан даатгуулагчдын тоо, бүсээр 2024 он*




Нийгмийн даатгалд хамрагдсан даатгуулагчдын нийт 64.9 хувь нь Улаанбаатар хотод төвлөрч байна. Харин орон нутгийн хэмжээнд Төвийн бүс 12.8 хувийг эзэлж буй нь хамгийн өндөр, Зүүн бүс 4.5 хувийг эзэлж хамгийн бага түвшинд байна.

СТАТИСТИК 2024

## 3.2.2 НИЙГМИЙН ДААТГАЛД АЛБАН ЖУРМААР ДААТГУУЛАГЧИД

Албан журмын нийгмийн даатгалд хамрагдсан даатгуулагчийн хувьд, эрэгтэйчүүд 15–34 нас болон 55-аас дээш насанд идэвхтэй хамрагддаг бол эмэгтэйчүүд 40–54 насанд давамгайлдаг нь насны бүлэг тус бүрд хөдөлмөр эрхлэлтийн хэв маяг, тэтгэвэрт гарах үеийн даатгалын хэрэгцээний ялгааг илэрхийлж байна.

*Зураг 3.19. Нийгмийн даатгалд албан журмаар даатгуулагчдын тоо, насны бүлэг, хүйсээр*




2024 онд албан журмын даатгалд нийт **996,769 хүн** хамрагдсан бөгөөд дийлэнх нь **ААНБ-ын ажилтан (79.0%)**, төсөвт байгууллагын ажилтан **(15.6%)** болон тэтгэвэр тогтоолгосон ажилтан **(8.1%)** зэрэг нь нийт даатгуулагчдын гол хэсгийг бүрдүүлж байна.

*Зураг 3.20. Нийгмийн даатгалд албан журмын хамрагдсан даатгуулагчийн тоо, аж ахуй нэгж байгууллагаар, 2024 он*




Албан журмын даатгалд хамрагдсан нийт **996,769** даатгуулагч байгаа бөгөөд үүний 685,118 нь нийслэл Улаанбаатар хотод (68.7%), 124,334 нь Төвийн бүсэд (12.5%), 85,148 нь Хангайн бүсэд (8.5%), 61,559 нь Баруун бүсэд (6.2%), 40,610 нь Зүүн бүсэд (4.1%) тус тус төвлөрсөн байна. Энэ нь даатгалын хамрагдалт болон бүс нутгийн хүн амын төвлөрөл, эдийн засаг, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг харьцуулах үндсэн статистик үзүүлэлт болж байна.

*Зураг 3.21. Албан журмын даатгалд даатгуулагчдын тоо, 2024 он*






## 3.2.3. САЙН ДУРААР НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД

2024 онд нийт **140,161** иргэн сайн дурын даатгалд хамрагдсанаас малчин, туслах малчид **38.4%,** хувиараа хөдөлмөр эрхлэгчид **36.8%**-ийг эзэлж байна. Бусад төрлийн даатгуулагчдын эзлэх хувь бага бөгөөд оюутан болон гадаадад ажиллаж буй иргэдийн оролцоо хамгийн бага байна.

*Зураг 3.22. Нийгмийн даатгалд сайн дураар хамрагдсан даатгуулагчийн тоо, 2024 он*



2024 онд сайн дурын даатгалд хамрагдагчдын **61.5%**-ийг эмэгтэйчүүд эзэлж, ялангуяа 30-49 насны бүлэгт тэдний оролцоо эрэгтэйчүүдээс тогтвортой өндөр байна. Харин 55 ба түүнээс дээш насны бүлэгт эрэгтэйчүүдийн оролцоо давамгайлж байгаа нь тэтгэвэрт гарах нас, даатгалын хугацааг нөхөх зорилготойгоор сайн дурын даатгалд хамрагдаж буйтай холбоотой гэж үзэж болно.

*Зураг 3.23. НД-д сайн дураар даатгуулагчдын тоо, насны бүлэг, хүйсээр*




2024 онд нийт 140,161 хүн сайн дурын даатгалд хамрагдсан бөгөөд хамгийн өндөр хувь нь нийслэлд (37.8%) бүртгэгдэж, бусад бүс нутгаар Хангай (24.8%), Төв (15.0%), Баруун (14.8%), Зүүн (7.6%) гэсэн дараалаар төвлөрсөн нь бүс нутгийн хүн амын бүтэц, хөдөлмөр эрхлэлтийн онцлогийг илтгэж байна.

*Зураг 3.24. Нийгмийн даатгалд сайн дураар хамрагдсан даатгуулагчийн тоо, бүсээр, эзлэх хувиар, 2024 он*



# НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТ



# НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ 2024 он

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО

**УЛСЫН ДҮН**

**2,723,231**

ЭХ, ХҮҮХДЭД ОЛГОХ ТЭТГЭМЖ **73.6%**

АХМАД НАСТАН, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭН, ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭХ, ЭЦЭГ БОЛОН НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ЗОРИЛТОТ ӨРХ, ИРГЭНД ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТУСЛАМЖ **26.4%**

## Нийгмийн халамжийн зардлын улсын нэгдсэн төсөв болон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь, 2024 он

ХАЛАМЖИЙН ЗАРДАЛ **2,305.0** тэрбум төгрөг

Улсын нэгдсэн төсөв **30,365.5** тэрбум төгрөг

Дотоодын нийт бүтээгдэхүүн **79,956.3** тэрбум төгрөг

Халамжийн зардлын эзлэх хувь **9.1%**

Халамжийн зардлын эзлэх хувь **2.9%**

## Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүний тоо 2021-2024 он
(Давхардсан тоогоор)

- 2021 он: **2,551,700** хамрагдсан иргэд
- 2022 он: **2,643,780** хамрагдсан иргэд
- 2023 он: **2,686,754** хамрагдсан иргэд
- 2024 он: **2,723,231** хамрагдсан иргэд

# БҮЛЭГ 4. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Монгол Улс 1990 оноос төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж улмаар төрийн санхүүжилттэй нийгмийн хамгааллын тогтолцоог халж нийгмийн даатгал, нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн тогтолцоог хөгжүүлсэн. 1995 онд Нийгмийн халамжийн анхны бие даасан хуулийг УИХ-аас батлан, 1997 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг "Улсын нийгмийн халамжийн газар" болон 21 аймаг, 9 дүүргийн Нийгмийн халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдийг анх байгуулсан.

Нийгмийн халамжийн анхны хууль батлагдсанаас хойш 2000, 2008 онд нэмэлт, өөрчлөлт оруулж, 1998, 2005, 2012 онд шинэчлэн найруулж байсан.

Монгол Улсад өнөөдрийн байдлаар нийгмийн халамжийн чиглэлийн дараах 6 хууль хүчин төгөлдөр үйлчилж байна:

- Нийгмийн халамжийн тухай
- Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай
- Ахмад настны тухай
- Алдар цолтон ахмад настанд нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай
- Эх, эцэг олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай

Эдгээр хууль тогтоомжийн хүрээнд 12 төрлийн халамжийн хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Үүнд:

1. Нийгмийн халамжийн тэтгэвэр
2. Асаргааны тэтгэмж
3. Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж
4. Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ
5. Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт олгох тэтгэмж
6. "Эхийн алдар" одонтой эхийн мөнгөн тусламж
7. Ахмад настанд үзүүлэх дэмжлэг, хөнгөлөлт, үйлчилгээ
8. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх хөнгөлөлт, тусламж
9. Хүүхдийн мөнгөн тэтгэмж
10. Насны хишиг
11. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ
12. Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ

# 4.1. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРДАЛ

## Төсөв, нийгмийн халамжийн сангийн зарцуулалтын томьёолол

2023 онд нийгмийн халамжийн сангийн төсөв 2.2 их наяд төгрөг байсан бол 2024 онд 2.3 их наяд төгрөг болж 6.5 хувиар өсөв. Халамжийн үйлчилгээ авч буй иргэдийн тоо 43.1 мянгаар нэмэгдэж, давхардсан тоогоор 2,723.2 мянгад хүрснээр 1.6 хувийн өсөлттэй байна.

*Зураг 4.1. Нийгмийн халамжийн сангийн зардлын улсын нэгдсэн төсөв болон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь, 2023–2024 он*




Нийгмийн халамжийн арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн ДНБ-нд эзлэх хувь нь 2000 онд 1.1, 2019 онд 1.8, 2021 онд 4.5, 2023 онд 3.1, 2024 онд 2.9 байсан бол 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2.7 байна.

Харин улсын нэгдсэн төсөвт эзлэх хувь нь 2000 онд 3.0, 2019 онд 5.8, 2021 онд 12.6, 2023 онд 9.9, 2024 онд 9.1 байсан бол 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 7.5 байна.

Хөгжиж буй орнуудын хувьд нийгмийн халамжийн зарцуулалт ДНБ-д эзлэх хувь дунджаар 1.6 хувьтай (ДБ, 2015) байдаг бөгөөд үүнтэй харьцуулахад Монгол Улсын нийгмийн халамжид зарцуулж байгаа зардал харьцангуй өндөр юм.

СТАТИСТИК 2024

*Зураг 4.2. Нийгмийн халамжийн сангийн зардлын бүтэц*




Нийгмийн халамжийн сангаас 2024 онд нийт 2.3 их наяд төгрөг зарцуулснаас 1.5 их наяд төгрөгийг хүүхдийн мөнгөн тэтгэмжид зарцуулсан байна. Зарцуулсан нийт зардлын 26.4 хувь буюу 600.9 тэрбум төгрөгийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, өрх толгойлсон эх, эцэг болон нийгмийн халамжийн зорилтот өрх, иргэнд олгох тэтгэвэр, тэтгэмж, тусламжид зарцуулжээ.

Харин 1,704.1 тэрбум төгрөг буюу нийт зардлын 73.6 хувийг 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж, ээж, одонтой эх, хүүхдийн мөнгө, насны хишиг, жирэмсэн эхийн тэтгэмж зэрэг амьжиргааны түвшин харгалзахгүй нийтлэг олгож байгаа хөтөлбөрт зарцуулсан.

*Зураг 4.3. Нийгмийн халамжийн сангийн зардлыг нэмэгдүүлсэн хөтөлбөрүүд*



Нийгмийн халамжийн нийт зардал, хамрах хүрээг нэмэгдүүлэхүйц хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсээр ирсэн. Тухайлбал насны хишгийг 2017 оноос, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжийг 2018 оноос тус тус эхлүүлсэн. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хэмжээг 2020 оноос эхлэн сард 20000 төгрөг байсныг 100000 төгрөг болгон 5 дахин нэмэгдүүлсэн нь нийгмийн халамжийн нийт зардлыг 2019 оны түвшингээс бараг 3 дахин өсгөсөн юм.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”–ийн 2.1.3.17-д “Улс төрийн амлалтаар өрх, иргэнд халамжийн нийтлэг мөнгөн шилжүүлэг олгохгүй байхаар нийгмийн хамгааллын эрх зүйн орчныг өөрчилнө.” гэж тусгасан.

*Зураг 4.4. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ*




Асаргааны тэтгэмж өмнөх оноос 15.3%-иар, нийгмийн халамжийн тэтгэвэр 15.4%-иар өссөн нь нийгмийн халамжийн бодлогын үр дүнг илтгэж байна.

## 4.2 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР

*Хүснэгт 4.1. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээнд хамрагдалт, хүний тоо, хувиар, 2024 он*

| Үйлчилгээний төрөл | Хүний тоо | Хувь |
|---|---|---|
| *Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээнд хамрагдсан нийт иргэд* | *2,723,231* | *100%* |
| Нийгмийн халамжийн тэтгэвэр | 61,003 | 2.2% |
| Асаргааны тэтгэмж | 77,844 | 2.9% |
| Онцгой тохиолдол болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж | 70,861 | 2.6% |
| Эх, хүүхдэд олгох тэтгэмж | 248,808 | 9.1% |
| Эхийн алдар одонтой эхчүүдэд олгох мөнгөн тусламж | 259,746 | 9.5% |
| Хүүхдийн мөнгөн тэтгэмж | 1,303,997 | 47.9% |
| Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ | 8,699 | 0.3% |
| Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ | 159 | 0.006% |
| Ахмад настанд үзүүлэх дэмжлэг, хөнгөлөлт, үйлчилгээ | 318,731 | 11.7% |
| Алдар цолтон ахмад настанд төрөөс олгох хөнгөлөлт, тусламж хөнгөлөлт | 3,63 | 0.013% |
| Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж | 49,505 | 1.8% |
| Хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ | 89,706 | 3.3% |



2024 оны байдлаар нийгмийн халамжийн үйлчилгээнд давхардсан тоогоор 2,723,231 хүн хамрагдсанаас хүүхдийн мөнгөн тэтгэмж дангаараа 47.9 хувь буюу 1,303,997 хүүхэд хамрагдсан нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Мөн ахмад настанд үзүүлэх дэмжлэг, хөнгөлөлт, үйлчилгээнд 318,731 хамрагдсан нийт хүний 11.7 хувийг эзэлж байна.

*Зураг. 4.5. Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ 2020 оноос хойш 3 удаа нэмэгдсэн байна.*




Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 288.0 мянган төгрөг, 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 325.0 мянган төгрөг, 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 375.0 мянган төгрөг болгон тус тус нэмэгдүүлсэн.

*Хүснэгт 4.2. Нийгмийн халамжийн тэтгэвэр авагч, төрлөөр /Нийгмийн халамжийн тухай хуулийн/ 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг*

| Тэтгэврийн төрөл | Хүний тоо | Сая.төг |
|---|---|---|
| *Нийгмийн халамжийн тэтгэвэр* | *61,003* | *242,634.8* |
| 65 насанд хүрсэн иргэн /Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1 дэх заалтын тайлбар хэсэгт заасан/ | 7,362 | 29,412.6 |
| 16 насанд хүрсэн одой иргэн | 120 | 483.6 |
| Хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн | 36,623 | 142,558.1 |
| Тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд | 16,883 | 70,126.3 |
| 18 хүртэлх насны дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй, өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэг | 15 | 54.2 |

Нийгмийн халамжийн тэтгэвэрт нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасны дагуу бүрэн болон хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэвэр авах эрх үүсээгүй дээрх 5 бүлгийн иргэд хамрагдаж байна.

Нийт тэтгэвэр авагчийн 60 хувийг хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 27.7 хувийг тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд тус тус эзэлж байна.

*Зураг 4.6. Нийгмийн халамжийн тэтгэвэр авагч, хүйсээр, сонгогдсон оноор*




Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2024 онд нийт 61,003 иргэн хамрагдсанаас 43.9 хувь нь эрэгтэй, 56.1 хувь нь эмэгтэй тэтгэвэр авагч байна.

*Зураг 4.7. Нийгмийн халамжийн тэтгэвэр авагчдын тоо, насны бүлэг, хүйсээр, 2024 он*




*Зураг 4.8. Нийгмийн халамжийн тэтгэвэр авагчдын тоо, хүйсээр, аймаг, нийслэлээр, 2024 он*



## 4.3. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ

### 4.3.1. АСАРГААНЫ ТЭТГЭМЖ

*Зураг. 4.9. Асаргааны тэтгэмжийн хэмжээ 2020 оноос хойш 3 удаа нэмэгдсэн байна.*




*Зураг 4.10. Асаргааны тэтгэмж авагчийн тоо, зарцуулсан зардал, тэрбум. төг, 2021-2024 он*




Асаргааны тэтгэмжид 2024 онд 77,844 иргэн хамрагдаж 220.4 тэрбум төгрөг зарцуулсан. Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асарч байгаа иргэнд олгох асаргааны тэтгэмж нийт асаргааны тэтгэмжийн 96.7 хувийг эзэлж байна. Байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа иргэнд олгох асаргааны тэтгэмж дангаараа нийт асаргааны тэтгэмжийн 55.3 хувийг эзэлж байна.

*Зураг 4.11. Зорилтод хэсэгт чиглэсэн нийгмийн халамжийн зардалд асаргаа болон амжиргааны тэтгэмжийн эзлэх хувь*



*Хүснэгт 4.3. Асаргааны тэтгэмж авагчдын тоо, төрлөөр, 2024 он*

| Үйлчилгээний төрөл | Хүний тоо | сая.төг |
|---|---|---|
| **Асаргааны тэтгэмж** | **77,844** | **220,433.5** |
| Бүтэн өнчин хүүхдийг үрчилж авсан болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа иргэн | 2,151 | 8,182.8 |
| Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон бие махбодын хохирол хүлээж хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа иргэн | 219 | 825.7 |
| Тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэн | 209 | 623.9 |
| Ахмад настныг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэн | 144 | 410.8 |
| Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэн | 65 | 213.1 |
| Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асарч байгаа иргэн | 75,265 | 210,801.0 |
| Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа | 17,166 | 48,825.0 |
| Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа | 15,064 | 45,702.8 |
| Байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа | 43,035 | 116,273.1 |

*Зураг 4.12. Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж*




Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид 2024 онд нийт 70,861 иргэн хамрагдаж, нийгмийн халамжийн сангаас 66.9 тэрбум төгрөгийг зарцуулсан. Үүнээс байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэл насны 15.178 хүүхдэд Засгийн газраас тогтоосон тухайн үеийн нийгмийн халамжийн тэтгэвэртэй тэнцүү хэмжээний тусламжийг сар бүр, байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны 55,683 иргэнд улирал бүр тэтгэмжийг олгосон.

## 4.3.2. ХҮҮХДИЙН МӨНГӨН ТЭТГЭМЖ

Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг Монгол Улсын 0-18 хүртэлх насны хүүхдэд сар бүр олгож байна. Нийгмийн халамжийн сангаас 2024 онд нийт 1,340,971 хүүхдэд 1,540.0 тэрбум төгрөгийн хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгосон байна. Хамрагдсан хүүхдүүдийг насны бүлгээр авч үзвэл 9-11 насны хүүхэд хамгийн өндөр хувьтай хамрагдсан байна.

*Зураг 4.13. 0-18 насны хүүхдийн мөнгөн тэтгэмж авагчдын тоо, насны бүлгээр, 2024 он*



*Зураг 4.14. Халамжийн зардалд хүүхдийн мөнгөн тэтгэмжийн эзлэх хувь*




## 4.3.3. ОНЦГОЙ ТОХИОЛДЛЫН ТЭТГЭМЖ

*Зураг 4.15. Онцгой тохиолдлын тэтгэмж,*




Онцгой тохиолдлын тэтгэмжийг дээрх 4 бүлгийн иргэдэд нэг удаа орон нутгийн төсвөөс олгодог. 2024 онд 1219 иргэнд 1.5 тэрбум төгрөгийн онцгой тохиолдлын тэтгэмжийг олгосон.

# 4.4. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

## 4.4.1. ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООНД ТҮШИГЛЭСЭН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

*Хүснэгт 4.4. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, төрлөөр*

| Үйлчилгээний төрөл | Хүний тоо | сая.төг |
|---|---|---|
| Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ | 8,699 | 3,370.8 |
| Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах | 2,031 | 125.9 |
| Зөвлөгөө өгөх | 254 | 20.0 |
| Сэргээн засах үйлчилгээнд хамруулах | 3,046 | 802.0 |
| Түр байршуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах | 36 | 30.7 |
| Өдрийн үйлчилгээнд хамруулах | 1,643 | 162.4 |
| Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах | 193 | 72.0 |
| Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах | 848 | 927.4 |
| Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2, 18.2.-т заасан өрх иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах | 648 | 1,230.5 |

## 4.4.2. ТӨРӨЛЖСӨН АСРАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

*Зураг 4.16. Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо, насны бүлгээр*




*Хүснэгт 4.5. Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэд, 2024 он*

| Үйлчилгээний төрөл | Бүгд | | Ахмад настан | | Хөгжлийн бэрхшээлтэй иргэн | |
|---|---|---|---|---|---|---|
| | Нийт | эмэгтэй | Нийт | эмэгтэй | Нийт | эмэгтэй |
| Улсын дүн | 507 | 202 | 316 | 144 | 191 | 58 |
| Төв аймгийн Батсүмбэр сум дахь Улсын асрамжийн газар / Ахмад настны үндэсний төв/ | 176 | 68 | 126 | 59 | 50 | 9 |
| Ховд аймаг дахь Баруун бүсийн ХБИ-ий нөхөн сэргээх төв | 18 | 18 | 6 | 9 | 12 | 9 |
| Баянхонгор аймаг дахь Ахмадын асрамж үйлчилгээний төв | 10 | 2 | 5 | 2 | 5 | 0 |
| Дорнод аймаг дахь Зүүн бүсийн ахмадын асрамж үйлчилгээний төв | 22 | 6 | 16 | 6 | 6 | 0 |
| Баян-өлгий аймаг дахь Ахмадын асрамж үйлчилгээний төв | 13 | 7 | 9 | 5 | 4 | 2 |
| Дорноговь аймаг дахь Говийн бүсийн ахмадын асрамж үйлчилгээний төв | 18 | 7 | 10 | 4 | 8 | 3 |
| Хөвсгөл аймаг дахь Ахмадын асрамж үйлчилгээний төв | 45 | 17 | 36 | 10 | 9 | 7 |
| Увс аймаг дахь Баруун бүсийн ахмадын асрамж үйлчилгээний төв | 15 | 11 | 7 | 6 | 8 | 5 |
| “Батгэрэлт-ирээдүй” ТББ-ын ХБИ-ий асрамжийн газар | 60 | 14 | 34 | 7 | 26 | 7 |
| “Ачлалт хүүхдүүд” ТББ-ын ХБИ-ий асрамжийн газар | 59 | 23 | 26 | 15 | 33 | 8 |
| “МС” Тереза эх ахмад настны асрамжийн төв /Яармаг/ | 42 | 0 | 20 | 0 | 22 | 0 |
| “МС” Тереза эх ахмад настны асрамжийн төв /Дарь-Эх/ | 29 | 29 | 21 | 21 | 8 | 8 |

## 4.4.3. АХМАД НАСТАНД ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ, ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

*Зураг 4.17. Ахмад настны дэмжлэг, хөнгөлөлт үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, насны бүлгээр, 2024 он*




*Хүснэгт 4.6. Ахмад настны дэмжлэг, хөнгөлөлт үйлчилгээнд хамрагдсан хүний тоо,төрлөөр, зарцуулсан хөрөнгөөр, 2024 он*

| Үйлчилгээний төрөл | Хүний тоо | сая.төг |
|---|---|---|
| Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт | 318,731 | 37,689.0 |
| Протезийн үнийн хөнгөлөлт | 26,869 | 3,966.7 |
| Ортопедийн хэрэгслийн үнийн хөнгөлөлт | 10,776 | 3,774.4 |
| Тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлт | 9,634 | 1,477.8 |
| Амралтын газарт амрах эрхийн бичгийн үнийн хөнгөлөлт | 35,373 | 8,161.1 |
| Сувиллын газарт амрах эрхийн бичгийн үнийн хөнгөлөлт | 25,754 | 6,718.4 |
| Эмчилгээ, сувилгаа зайлшгүй шаардлагатай ахмад настанд магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувиллын замын зардал, эрхийн бичгийн үнийн хөнгөлөлт | 49,901 | 7,916.2 |
| Хүндэт донор ахмад настанд магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувиллын замын зардал, эрхийн бичгийн үнийн хөнгөлөлт | 552 | 529.3 |
| Тэжээн тэтгэх хүүхэдгүй эсхүл хууль ёсны тэжээн тэтгэгч нь дэмжлэг туслалцаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон ахмад настанд орон сууцны хөлс, түлш худалдан авахад зориулан жилд нэг удаа үзүүлэх хөнгөлөлт | 4,591 | 637.3 |
| Хүндэт донор ахмад настанд орон сууцны хөлс, түлш худалдан авахад зориулан жилд нэг удаа үзүүлэх хөнгөлөлт | 1,164 | 1170.7 |
| Нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй ахмад настан нас барвал нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжтэй тэнцүү хэмжээний тусламж | 422 | 844.0 |
| Нийслэлээс 1000 ба түүнээс дээш километр алслагдсан газарт байнга оршин суудаг ахмад настан аймгийн эрүүл мэндийн байгууллагын эмнэлэг хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд эмчүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд унааны нэг талын зардлын хөнгөлөлт | 2,021 | 437.9 |
| Ахмад настанд үзүүлэх хүндэтгэл | 147,956 | 2 746.0 |
| Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ | 3,718 | 309.3 |

*Зураг 4.18. Алдар цолтон ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлтөд хамрагдсан хүний тоо, зарцуулсан хөрөнгө, сая төгрөг, 2024 он*




*Зураг 4.19. Алдар цолтон ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлтөд хамрагдсан хүний тоо, цолны төрлөөр, 2024 он*



## 4.4.4. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

*Хүснэгт 4.7. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид хамрагдсан хүний тоо, зарцуулсан хөрөнгө, сая төгрөг*

| Үйлчилгээний төрөл | Хүний тоо | сая.төг |
|---|---|---|
| Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт | 49,505 | 11,561.6 |
| Орон сууцны хөлс, түлш худалдан авахад зориулан жилд нэг удаа үзүүлэх хөнгөлөлт | 26,840 | 3,776.2 |
| 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоодод хийлгэсэн протезийн үнийн хөнгөлөлт | 28 | 8.7 |
| ҮОМШӨ-ийн даатгалын сангаас хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн протезийн үнийн хөнгөлөлт | 2,038 | 416.5 |
| 18 хүртэлх насны хүүхэд, түүнчлэн ҮОМШӨ-ийн даатгалын сангаас сэргээн засалттай холбоотой хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн ортопедийн хэрэгслийн үнийн хөнгөлөлт | 2,558 | 967.9 |
| Тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлт | 2,299 | 922.6 |
| Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн цэцэрлэг сургуульд ирж, очих унааны зардлын хөнгөлөлт | 6,702 | 1,352.7 |
| Насанд хүрсэн бүрэн хараагүй, сонсголгүй, хэл ярианы бэрхшээлтэй хүний харилцаа холбооны зардал | 4,134 | 888.5 |
| Бүрэн хараагүй иргэн | 2,333 | 487.8 |
| Бүрэн сонсголгүй иргэн | 1,611 | 357.4 |
| Хэл ярианы бэрхшээлтэй иргэн | 190 | 43.4 |
| Дотоодын рашаан сувилалд сувилуулах шаардлагатай хүний ирж, очих унааны зардал, ор хоногийн зардлын хөнгөлөлт | 3,029 | 848.7 |
| Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд 100 хувь | 591 | 258.3 |
| Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асран халамжилж яваа иргэнд 50 хувь | 478 | 138.8 |
| ҮОМШӨ-ний даатгалын сангаас хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 50 хувь | 1,960 | 451.6 |
| Нийслэлээс 1000 ба түүнээс дээш километр алслагдсан газарт байнга оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй хүн аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд эмчүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд унааны нэг талын зардлын хөнгөлөлт | 801 | 253.1 |
| Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд зусланд амарвал эрхийн бичгийн үнийн хөнгөлөлт | 14 | 2.7 |
| Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүн болон хүүхэд нас барвал түүний оршуулгын зардлын тусламж | 1,062 | 2,124.0 |

## 4.4.5. НАСНЫ ХИШИГ

*Зураг 4.20. Насны хишиг тэтгэмж авагчдын тоо, насны бүлгээр, зарцуулсан хөрөнгө, сая төгрөг, 2024 он*




2024 онд Насны хишиг тэттгэмж авагчдын 44.2 хувийг 65-69 настай, 39.1 хувийг 70-79 настай, 14.6 хувийг 80-89 настай, 2.1 хувийг 90, түүнээс дээш настай ахмад настан тус тус эзэлж байна.

## 4.4.6. ЭХИЙН АЛДАР ОДОН

*Зураг 4.21. Эхийн алдар одонгийн мөнгөн тусламжид хамрагдсан иргэд, төрлөөр, зарцуулсан хөрөнгө, сая төгрөг*



*Зураг 4.22. Эхийн алдар одонгийн мөнгөн тусламж асван хүний тоо, насны бүлгээр, 2024 он*




2024 оны байдлаар 259,746 эхчүүдэд “Эхийн алдар” одонгийн мөнгөн тусламжид 32.0 тэрбум төгрөгийг олгосон байна. Насны бүтцийн хувьд 40–64 насны эхчүүд хамгийн их буюу нийт эхчүүдийн 54 хувийг эзэлсэн бөгөөд тэдгээрт нийт мөнгөн тусламжийн 50.6 хувийг олгожээ.

Эхийн алдар одонтой нийт эхийн 52 хувийг 55, түүнээс дээш насны эхчүүд бүрдүүлж байна. Үүний 23.2 мянга буюу 17.1 хувийг 55–59 насны эхчүүд, 31.0 мянга буюу 22.9 хувийг 60–64 насны эхчүүд, 30.3 мянга буюу 22.4 хувийг 65-69 насны эхчүүд, 21.2 мянга буюу 15.6 хувийг 70-74 насны эхчүүд тус тус эзэлж байна.

## 4.4.7. ЭХ, ЭЦЭГ, ОЛОН ХҮҮХЭДТЭЙ ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭХ, ЭЦЭГТ ОЛГОХ ТЭТГЭМЖ

*Зураг 4.23. Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн дагуу олгосон тэтгэмж авсан хүний тоо, зарцуулсан зарцуулсан хөрөнгө, 2024 он*




Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийг 2017 онд баталж, 2018 оноос хэрэгжүүлсэн. Хуулийн хүрээнд дээрх 4 төрлийн тэтгэмжийг олгож байна. Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт олгох тэтгэмжид 2024 онд нийт 248,808 иргэн хамрагдаж, 103.6 тэрбум төгрөгийг зарцуулсан.

*Зураг 4.24 Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн хүрээнд тэтгэмж авсан хүний тоо, аймаг, нийслэлээр, 2024 он*




Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн хүрээнд тэтгэмж асван хүний 45.7 хувь нь нийслэлд, 54.3 хувь нь орон нутагт амьдарч байна.

## 4.4.8. ХҮНС ТЭЖЭЭЛИЙН ДЭМЖЛЭГ

*Зураг 4.25. Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ авсан хүний тоо, зарцуулсан хөрөнгөөр, 2024 он*




Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 2024 онд 17,054 өрхийн 89,706 иргэнийг хамруулж, нийгмийн халамжийн сангаас 13.8 тэрбум төгрөг зарцуулсан. Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний мөнгөн дүнг насанд хүрсэн иргэнд 16,000, хүүхдэд 8,000 төгрөгөөр тооцон сар бүр олгосон.

*Зураг 4.26. Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ авсан хүний тоо, аймаг, нийслэлээр, 2024 он*




Уг үйлчилгээг авсан насанд хүрсэн 44,399 хүнээс 21,515 нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өрх толгойлсон эх, эцэг, жирэмсэн, бага насны хүүхдээ асарч байгаа зэрэг иргэд байна. Харин 22,884 нь хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай хүн байгаа бөгөөд үүнээс ажил хөдөлмөр эрхэлдэг 14,346 хүн байна. Хөдөлмөрийн нөхцөл шалгуур зайлшгүй биелүүлэх шаардлагатай 8,538 иргэнээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нөхцөл шаардлага хангасан буюу журмын 1.4.1-д заасан "ажил хайж аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн" иргэн 3,059, журмын 1.4.2-т заасан "ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээнд хамрагдаж, зөвлөгөө авсан" иргэн 1,732 иргэн тус тус байна.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй
дүүргийн 4-р хороо, Нэгдсэн Үндэстний гудамж-5
Улаанбаатар-15160

И-мэйл: info@mflsp.gov.mn
Утас: +(976) 51-261553